



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ЕБС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ХЭРЭГЖИВ

УЛААНБААТАР 2024

СУДАЛГААНЫ БАГ

Багийн ахлагч: **Г.Бүрэнжаргал** Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Доктор (Ph.D).

Зөвлөх: **С.Санжаабадам** Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Доктор (Ph.D), проф

У.Туяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Доктор (Ph.D), проф

Багийн гишүүд: **Б.Энхбаяр** Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, дэд проф.

Ц.Лхагвасүрэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, дэд проф.

Б.Баярмаа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

М.Хүрэлтогоо Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

А.Мөнхмагнай Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

О.Манзушир Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

П.Тунгалагтамир Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Б.Батцэнгэл Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Д.Наранцэцэг (гэрээт судлаач)

Д.Эрдэнэчимэг (гэрээт судлаач)

ТАЛАРХАЛ

Уг судалгааны ажлыг гүйцэтгэх боломжийг олгосон НҮБ-ын Хүүхдийн Сангийн баг, хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны ажлын явцад арга зүйн дэмжлэг үзүүлэн, зөвлөсөн, хамтран ажилласан багийн гишүүд болон зөвлөхүүддээ мөн Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) П.Чимэдцэрэн, Гамшиг судлалын төвийн эрхлэгч доктор (Ph.D) Т.Өсөхжаргал, тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Солонго нартаа талархал илэрхийлье.

Судалгаанд идэвхтэй хамрагдаж үнэт мэдээллээ хуваалцсан Баянхонгор, Дундговь, Сүхбаатар аймгийн орон нутгийн удирдлагууд, Онцгой байдлын газар, Боловсролын газрын гамшиг хариуцсан мэргэжилтэнүүд болон тус аймгийн түүвэрт сонгогдсон сумдын ЕБС-ийн захирал, менежер, нийгмийн ажилтан, багш, сурагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад талархал илэрхийлье.

Та бүхний хичээл зүтгэлээр энэхүү судалгааны үндсэн мэдээлэл цугларч, тайлан бичих боломж бүрдсэн билээ.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ТОВЧИЛСОН ҮГС	9
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	10
УДИРТГАЛ.....	12
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	14
Зорилго, зорилт	14
Судлах зүйл	14
Судалгааны арга, аргачлал	14
Судалгааны хамрах хүрээ	15
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	16
НЭГ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЗУДЫН ҮЕИЙН ЕБС-ИЙН ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	18
1.1. Онцгой нөхцөл байдал/зуд сурагчдын хичээл сургалтад нөлөөлсөн байдал.	18
1.2. Онцгой нөхцөл байдал/зудын сурагчдын суралцахуйд гарсан бэрхшээл.....	24
1.3. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, арга зүй	25
1.4. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны хамтын ажиллагаа	30
1.5. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны хэрэгжилт.....	34
1.6. Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал	37
ХОЁР. СУРГУУЛИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	41
2.1. ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт.....	41
2.2. ЕБС-иуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулсан эсэхэд хийсэн шинжилгээ	43
2.3. Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ түүнд хийсэн шинжилгээ	47
ГУРАВ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕИЙН СУРГАЛТЫН ОРЧНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ.....	60
3.1. Дотуур байрны барилга байгууламж.....	60
3.2. Гадаад орчин	61
3.3. Анхны тусламжийн багц	66

ДҮГНЭЛТ	70
ЗӨВЛӨМЖ	73
НОМ ЗҮЙ	76

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Зудын нөхцөл байдлаас хамаарсан хичээл таслалт, хувиар.....	19
Хүснэгт 2. Регрессийн шинжилгээ, зудын нөхцөл байдлын хичээл сургалтад нөлөөлсөн байдал.....	19
Хүснэгт 3. Сурагчдын хичээлд ирээгүй хоног, хувиар	20
Хүснэгт 4. Хичээлдээ ирэхгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар	22
Хүснэгт 5. Хичээлийн төлөвлөлтийн хугацаа, хувиар	25
Хүснэгт 6. Хичээлийн төлөвлөлтөд туссан арга зүй, хувиар	27
Хүснэгт 7. Хичээлийн төлөвлөлтөд боловсролын ялгаатай хэрэгцээт байдлыг тусгасан байдал, хувиар.....	28
Хүснэгт 8.Зудын нөхцөл байдлын үед сурагчдыг хичээлд бүрэн оролцуулсан байдал, хувиар.....	29
Хүснэгт 9. Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд орон нутгийн эмнэлгийн байгууллагын оролцоо туссан байдал, хувиар.....	33
Хүснэгт 10. Сурагчдад нэмэлт давтлага өгсөн байдал, хувиар	35
Хүснэгт 11.“Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу боловсруулсан эсэхэд хийсэн шинжилгээ /аймгаар, сумдаар/	44
Хүснэгт 12. “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г загварын дагуу боловсруулсан байдал.....	45
Хүснэгт 13. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний бүтэц.....	46
Хүснэгт 14. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний бүтэц.....	46
Хүснэгт 15. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний хавсралт, аймаг, сумдаар	47
Хүснэгт 16. Гамшгийн өмнө хэрэгжүүлэх арга хэмжээ	48
Хүснэгт 17. Шалгуур үзүүлэлт хэсэгт тусгасан үйл ажиллагаа	51
Хүснэгт 18. Шалгуур үзүүлэлт хэсэгт тусгасан арга хэмжээ	51
Хүснэгт 19. Гамшгийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээ.....	52
Хүснэгт 20. Гамшгийн дараа хэрэгжүүлэх арга хэмжээ	53
Хүснэгт 21. Баянхонгор аймгийн “16” сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд аюулгүй цэгт цугларах арга хэмжээг төлөвлөсөн байдал.....	54
Хүснэгт 22. Гамшгийн өмнө, үед, дараа хэрэгжүүлэх арга хэмжээг харьцуулсан	54
Хүснэгт 23. “Гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-нд тусгах арга хэмжээг “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан байдал.....	55
Хүснэгт 24. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хугацааг тусгасан байдал.....	55
Хүснэгт 25. Хэрэгжүүлэх арга хэмжээг томилгоожуулсан байдал	56
Хүснэгт 26. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн төрөл тус бүрээр боловсруулсан байдал	57

Хүснэгт 27. Зудын эрсдэлийн тойм мэдээ.....	58
Хүснэгт 28. Сургууль, дотуур байр нь эмнэлэг, онцгой байдлын, том оврын машин орж гарах гарцтай эсэх.....	62
Хүснэгт 29. ... аймгийн сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний багаж хэрэгслийн тооцоо, жишээгээр.....	62
Хүснэгт 30. Аюул тохиолдсон үед хэрэглэж болох багаж, хувиар	64
Хүснэгт 31. Галын аюулын үеийн хэрэгслэл гал унтраах МРЯ-4 ажиллагаатай эсэх, тоо ширхэг	64
Хүснэгт 32. Аюултай үед ашиглах элс ба эсгийний тоо, хувиар	65
Хүснэгт 33. Онцгой байдлын үед ашиглагдах хөрөө, сүх, лоомны тоо, хувиар.....	65
Хүснэгт 34. Аюул ослын үед хэрэглэгдэх гагнуур, сантехник, цахилгааны багаж.....	65
Хүснэгт 36. Сургууль, дотуур байрны дотоод орчны аюулгүй байдал буюу орц, гарц	66
Хүснэгт 38. Газар хөдлөлт болон аяга зайлуулагч, салхины хүчийг тэсвэрлэх чадвар	67

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Зудын нөхцөл байдал хичээл сургалтад нөлөөлсөн байдал, хувиар (менежерүүдийн хариултаас).....	18
Зураг 2. Зудын нөхцөл байдал нь хичээл сургалтад нөлөөлсөн байдал, хувиар (багш нарын хариултаас).....	18
Зураг 3. Зудын нөхцөл байдлын сургалтад сөргөөр нөлөөлсөн байдал, багш нарын хариулт, хувиар	19
Зураг 4. Хичээлийн таслалт ангиар, хувиар	20
Зураг 5. 14 хоногоос дээш хугацаагаар сурагчдын хичээлдээ ирээгүй байдал, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр).....	21
Зураг 6. Хичээлд ирээгүй сурагчдын хүйсийн харьцаа, хувиар.....	21
Зураг 7. Сурагчдын хичээлдээ ирээгүй шалтгаан, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)	22
Зураг 8. Хичээлд ирээгүй сурагчдын сургууль завсардах магадлал, хувиар (аймаг тус бүрээр)	23
Зураг 9. Зудын үеийн нөхцөл байдлын үеийн анги танхмын дулааны байдал, хувиар (аймаг тус бүрээр)	23
Зураг 10. Суралцахуйн бэрхшээлийн талаарх багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)	24
Зураг 11. Төлөвлөгөө боловсруулах үеийн хамтрагч талууд, хувиар.....	25
Зураг 12. Цахим болон зайн сургалтын төлөвлөгөө тухайн үедээ боловсруулдаг гэж үзсэн багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр).....	26
Зураг 13. Цахим болон зайн сургалтын явуулах боломж, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)	27
Зураг 14. Хичээлийн төлөвлөлтөд сурагчдын бие даасан байдал туссан байдал, хувиар.....	29
Зураг 15.Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны оролцоо, хувиар.....	32
Зураг 16.Онцгой нөхцөл байдлын үед багш нарын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хувиар.....	34
Зураг 17. Сурагчдад нэмэлт давтлага өгч байсан давтамж, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр).....	35
Зураг 18. Тулгамдаж байсан асуудал, хувиар.....	37

ТОВЧИЛСОН ҮГС

БЯ	Боловсролын Яам
БЕГ	Боловсролын Ерөнхий Газар
БСҮХ	Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
БГ	Боловсролын Газар
ГСҮХ	Гамшиг Судлалын Үндэсний хүрээлэн
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ҮСГ	Үндэсний Статистикийн газар
БУМС	Боловсролын удирдлагын мэдээллийн систем
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
БЕХ	Боловсролын Ерөнхий Хууль
ГХХ	Гамшгаас Хамгаалах хууль
ОБ	Онцгой байдал
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР¹

Зуд гол төлөв байгалийн эрхшээл нөлөөнөөс болж, хүн малын идэш ууш нэн ховордож нийтээр маш их гачигдал үзэх цаг үе (Цэвэл, Я., 1966).

Мөсөн буюу Төмөр зуд цаг зуурын дулааралт, хүйтэрлийн улмаас цасны өнгөн хэсэг буюу гүнд мөсөн бүрхэвч тогтсоноос мал бэлчээрлэх боломжгүй болсон.

Цагаан зуд цас, их хэмжээгээр орж, хүйтэнтэй хавсарсан зудыг гэнэ. Цас байн байн их орж, хүйтний эрч эрс чангаран мал сүрэг бэлчих аргагүй болж, өвс тэжээлээр гачигдан зутарч, улмаар тарга хүч муутай мал олноор хорогддог.

Онцгой байдал аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг.

Гамшиг аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг.

Гамшгийн эрсдэл гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг.

Аюул гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг.

Эмзэг байдал гэж аюулт үзэгдэл, осолд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг.

¹ <https://legalinfo.mn/mn/detail/12458>

Гамшгийн зарлан мэдээлэл гэж олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг.

Эрэн хайх, аврах ажиллагаа гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг.

Мэргэжлийн анги гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг.

Гамшгийн онцгой нөхцөл байдал гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг.

Гамшгаас урьдчилан сэргийлэх гэж аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг.

Бэлэн байдал гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг.

УДИРТГАЛ

Уур амьсгалын өөрчлөлт сүүлийн хэдэн арван жилийн турш хөгжлийг сааруулж, эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж улмаар хүүхдийн суралцахуй, боловсрол эзэмших арга хэлбэрт өөрчлөлт оруулах хүчин зүйл болж байгааг Хувьсаж буй боловсрол дэлхий нийтийн хэлэлцүүлгээр гарган тавьсан байна. Монгол орны цаг уурын эрс, тэс нөхцөл байдал (өвөлдөө зудын байдал хүндрэх, түүхий нүүрсний хэт их хэрэглээнээс шалтгаалсан агаарын бохирдол) зуны улиралд хур тунадас ихээр орох (үер ус) эсвэл ган гачиг нүүрлэх (ган гачгаас шалтгаалсан хүндрэлтэй зуд) зэрэг уур амьсгалын чиг хандлага Монгол Улсын боловсролын салбарт сөрөг нөлөө үзүүлдгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн 4 улсыг хамруулан хэрэгжүүлсэн “Боловсролд уур амьсгалын үзүүлэх нөлөөлөл” судалгаанд дурджээ².

Хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд буюу 2023 оны 11 дүгээр сараас 2024 оны 05 дугаар сар хүртэл агаарын температур буурч, хүйтний эрч чангарч, их хэмжээний цас үргэлжлэн орсноор зуд болж зам даваа хаагдаж, мал бэлчээрлэх боломжгүй болсон байна. Зудын нөхцөлд мал ихээр хоргодож өрхийн амьжиргаа буурснаас малчид сэтгэл зүйн таагүй байдалд автах, улмаар тухайн өрхийн хүүхдийн суралцах үйлд бэрхшээл тулгарах, эцэг эхийн зүгээс хүүхдэд үзүүлэх дэмжлэг сулрах, хүүхэд өөрөө сэтгэл зүйн тогтворгүй байдалд өртөх зэрэг хүндрэл үүсэж байна. Үүнээс гадна онцгой нөхцөл байдлын улмаас малчин өрхийн хүүхдүүд сургуульдаа урт богино хугацаагаар явж чадахгүй байх, сургуульдаа ирсэн үедээ гэртээ харьж чадахгүй байх нь нийтлэг болдог³.

Нүүдлийн мал аж ахуйн онцлогтой холбоотойгоор малчид үүрэн холбооны сүлжээ нэвтрээгүй газар байрлах, кабелийн сүлжээ орохгүй байх, сүлжээ муу орох зэрэг асуудлуудтай нийтлэг тулгардаг. Дээрх нөхцөл байдал нь малчдын хүүхдүүд цахим хичээлд хамрагдаж чадахгүй байх, нөгөө талаас багш ажилчид малчин өрхүүдтэй холбоо барих, суралцагчдын гүйцэтгэлд тасралтгүй дэмжлэг үзүүлэх боломж хязгаарлагдмал байдаг нь манай улсын онцлог болж байна. Иймээс онцгой нөхцөл байдал болж байгаа болон болоод өнгөрсөн хойно нь арга хэмжээ авахаас илүүтэй урьдчилан төлөвлөж, эрсдэлийг бууруулахад боловсролын салбар суралцах хэрэгцээтэйг сүүлийн жилүүдийн нөхцөл байдал харуулж байна. Иймээс бид онцгой нөхцөл байдлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны хүртээмж, чанарын асуудлыг тандан судлах шаардлагатай болсон юм.

²НҮБ-ын ХС, “Боловсролд уур амьсгалын үзүүлэх нөлөөлөл” судалгааны тайлан, 2019

³ БСҮХ, Боловсролын судалгааны монгол сэтгүүл, Боть 28(1), 2023.06

Энэ удаагийн судалгаагаар боловсролын бодлого боловсруулахад онцгой нөхцөл байдлыг авч үздэг эсэхийг онцлоогүй хэдий ч, орон нутаг сургуулийн түвшинд онцгой нөхцөл байдлын үеийн боловсролын бодлогын хэрэгжилтийг тандсан болно. Мөн уг судалгаа нь боловсролын болон гамшгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллагууд онцгой нөхцөл байдлын үеийн суралцагчдын боловсролын хүртээмж, чанарын асуудлаар хамтран хэрэгжүүлж байгаа практик үр дүнд чиглэсэн болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт судалгааны ажлын зорилго, зорилт, судлах зүйл, судалгааны арга аргачлал, судалгааны хамрах хүрээг орууллаа.

Зорилго, зорилт

Онцгой нөхцөл байдлын үед ЕБС-ийн хичээл, сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэй, тасалдалгүй зохион байгуулахад бэлэн байдлыг тандан судлахад оршино.

Зорилт:


1. ЕБС нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон нутгийн салбартай хамтран сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөлт (гамшгийн өмнө, үед, дараа)-ийг хэрхэн боловсруулдаг болон төлөвлөлтөд хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар болон зайнаас сургах талаар тусгасан байдлыг тодруулахаас гадна сайжруулах боломжийг авч үзэх,
2. Онцгой нөхцөл байдлын үед ЕБС-ийн хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хүргэх талаар орон нутгийн засаг захиргаа бусад холбогдох байгууллага, эцэг эх асран хамгаалагчдын хамтын оролцоог тодруулах
3. Онцгой нөхцөл байдал, гамшигт өртсөн сурагчдад зориулан сургуулийн зүгээс авч буй арга хэмжээ, хэрэгжилтийн үйл ажиллагааг тодруулах,
4. Онцгой нөхцөл байдалд өртсөн сургууль, сурагчдад тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодруулах.

Судлах зүйл

1. Орон нутгийн болон сургууль хоорондын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний уялдаа
2. Сургууль болон бусад холбогдох байгууллага, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагаа
3. Онцгой нөхцөл байдалд өртсөн сумын ЕБС-ийн сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, нөлөөлж буй хүчин зүйл.

Судалгааны арга, аргачлал


Судалгааны мэдээллийг цуглуулахдаа тоон болон чанарын аргыг ашиглав. Үүнд:



Судалгааны мэдээллийг SPSS 26 программаар дескриптив болон хүчин зүйлийн шинжилгээ хийж, ANOVA t-test тооцов.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд түүвэрт сонгогдсон аймаг, сумдын Тамгын газар, Онцгой байдлын газар, Боловсролын газар, Ерөнхий боловсролын сургуулиудын төлөөллүүдийг хамруулан мэдээлэл цуглуулав.



2023-2024 оны хичээлийн жилд онцгой нөхцөл байдалд өртсөн сумын сургуулийг зориудын түүврээр сонголоо.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2023-2024 оны хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд (2023.11 сараас 2024.03 сар хүртэл) улсын хэмжээнд цагаан зудтай хэмээн бүртгэгдсэн 16 аймгийн 130 сум байв. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны мэдээллийг 5 дугаар сард цуглуулсан ба энэ үед төмөр зудтай хаваржилт хүндрэлтэй байсан Баянхонгор, Сүхбаатар, Дундговь аймгуудын алслагдсан сумдыг хамруулав.

Судалгаанд цагаан болон төмөр зудын үеэр хичээл сургалтын үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байсан буюу сургалтын үйл ажиллагаа нь нөхцөл байдлаас хамааран хаагдах хэмжээнд хүрээгүй сургуулиуд хамрагдсан болно.

Судалгаанд түүвэрт хамрагдсан аймаг, сумдын засаг дарга 18, онцгой байдлын мэргэжилтэн 3, БШУГ-ын мэргэжилтэн 3, ЕБС-ийн захирал 18, сургалтын менежер 31, нийгмийн ажилтан 21, сэтгэл зүйч 4, анги удирдсан багш 449, дотуур байрны багш 20, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч 54, бага, дунд, ахлах ангийн сурагч 232⁴ хамруулж мэдээлэл цуглуулав.

Аймаг, сумын Засаг дарга, Боловсролын газрын мэргэжилтэн, Онцгой байдлын газрын мэргэжилтэн

Ганцаарчилсан ярилцлагын аргаар аймаг, сумын засаг даргаас мэдээлэл цуглуулсан ба насны хувьд 35-60 хүртэлх насныхан байсан ба 70 гаруй хувь нь төрийн албанд 11-46 жил, засаг даргаар 8-26 дахь жилдээ ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан БГ-ын гамшиг онцгой нөхцөл байдал хариуцсан мэргэжилтэнүүдийн хувьд 31-35 насныхан байсан ба тухайн байгууллагад 2-5 ажиллаж байна.

ОБГ-ын мэргэжилтэнүүд 31-40 насныхан тухайн байгууллагад 2-15 дахь жилдээ ажиллаж байна.

Сүргүүлийн захирал, сургалтын менежер, багш, дотуур байрны багш, сэтгэл зүйч

Судалгаанд хамрагдсан ЕБС-ийн захиралууд насны хувьд 30-аас дээш насныхан байсан ба 70 орчим хувь нь 10 дахь жилдээ ажиллаж буй, тэргүүлэх зэрэгтэй байна.

Сургалтын менежерүүд 36-40 насныхан, 81.0 хувь нь эмэгтэй, менежерээр 6-15 жил ажиллаж байгаа туршлагатай.

Багш нарын хувьд 31-40 насныхан, 89.7 хувь эмэгтэй, 37.9 хувь нь бага ангийн багш байна. Багш нарын 20.0 хувь нь 6-10 жил, 20.3 хувь нь 16-20 жил ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 4 нь сэтгэл зүйчтэй байсан ба судалгаанд 26-30 насны 1, 31-35 насны 2, 46-50 насны 1 сэтгэл зүйч хамрагдсан байна. Сүргүүлийн

⁴ Бага ангийн 52, дунд ангийн 152, ахлах ангийн 28 сурагч

сэтгэл зүйчид нь 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа ба 16-20 жилдээ 1 хүн ажиллаж байна⁵.

Дотуур байрны багшаар 1-5 жил ажилласан 45.0 хувь, 6-14 жил ажиллаж байгаа багш 20.0 хувь, 17-22 жил ажиллаж байгаа багш 15.0 хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан багшийн ажилласан жилийг авч үзэхэд 35.0 хувь нь 6-22 жил ажиллаж байгаа нь онцгой байдлын үед ажиллах, сурагчдыг дэмжих талаар ажлын туршлагатай гэж үзэж болохоор байна.

Дотуур байрны багшаар монгол хэл, уран зохиолын багш, түүх нийгмийн багш, биеийн тамирын багш сэтгэл зүйч, бага ангийн багш нар ажиллаж байгаа нь сурагчид гэрийн даалгавар хийх, хичээлээ давтахад нь зөвлөн туслах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх давуу талтай байна.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид

Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчидтай 49 удаагийн ганцаарчилсан ярилцлага хийсний 75.0 орчим хувь нь багийн харьяат байна. Хүйсийн хувьд 83.7 хувь нь эмэгтэй, 16.3 хувь нь эрэгтэй байна. Эцэг эх, асран хамгаалагчдын 93.9 хувь нь малчин, үлдсэн 6.1 хувь нь бусад ажил эрхэлдэг байна. Тэдний боловсролын түвшинг авч үзвэл 4.1 хувь нь бага, 4.1 хувь нь бүрэн бус дунд, 55.1 хувь нь бүрэн дунд, 4.1 хувь нь тусгай дунд, 6.1 хувь нь дээд боловсролтой байна. Сургуулийн насны 1-3 хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын эзлэх хувь 91.8, бусад нь 4-5 хүүхэдтэй байна.

Сурагчид

Судалгаанд хамрагдсан бага, дунд, ахлах ангийн сурагчтай 36 удаагийн ярилцлага хийсний 75.0 хувьд нь сумын төвийн сургуулийн сурагчдыг хамруулжээ. Хүйсийн хувьд 48.9 хувь нь эмэгтэй, 50.2 хувь нь эрэгтэй сурагч хамрагдсанаас 31.0 хувь нь дотуур байранд сууж байна.

⁵ БШУ-ны сайдын А/266 дугаар тушаалаар 2021 оноос ЕБС-д сэтгэл зүйч ажиллуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах болсон бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 3 сургууль тутмын 1 нь мэргэжлийн сэтгэл зүйчтэй болсны зэрэгцээ “Боловсролын сэтгэл зүйч”-ийн мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. БШУСайдын тушаалаар 2018 онд “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам” батлагдсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийн 3.3-т “нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг хүүхдийн сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйч үзүүлнэ” гэж тусгасан байна. Энэ журмаар сургуулийн сэтгэл зүйч нь онцгой байдал, байгалийн гамшигт үзэгдлийн үед сурагчдын насны онцлогт тохирсон сэтгэл зүйн зөвлөгөөг багш болон эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран зохион байгуулахыг зохицуулсан байна.


НЭГ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЗУДЫН ҮЕИЙН ЕБС-ИЙН ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. Онцгой нөхцөл байдал/зуд сурагчдын хичээл сургалтад нөлөөлсөн байдал

2023-2024 оны зудын нөхцөл байдал нь хичээл сургалтад хэрхэн нөлөөлсөн талаар сургуулиудын сургалтын менежер, багш нараас асуулгаар тодрууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад, 2023 оны зудын нөхцөл байдал нь хичээл сургалтад сөргөөр нөлөөлсөн дүр зураг менежерүүдийн асуулгад хариулсан байдлаас харагдаж байна.


Зураг 1. Зудын нөхцөл байдал хичээл сургалтад нөлөөлсөн байдал, хувиар (менежерүүдийн хариулт)



Дээрх зургаас харахад, асуулгад оролцогчдын 36.0 хувь нь их, 16.0 хувь нь маш ихээр нөлөөлсөн гэж үзсэн байна.

Үүнийг багш нараас тодруулахад, ихэнх нь ихээр нөлөөлснийг онцолсон байна.


Зураг 2. Зудын нөхцөл байдал нь хичээл сургалтад нөлөөлсөн байдал, хувиар (багш нарын хариулт)



Ийнхүү сургалтын менежер багш нарын хариулт ялгаатай буюу өөрөөр хэлбэл, менежерүүд багш нартай харьцуулахад илүү ихээр нөлөөлсөн гэж үзсэн нь сургуулийн

нийт сурагчдын хувьд нөлөөллийг хэлж байгаа бол багш нар зөвхөн ангийн хүрээнд сөрөг нөлөөллийг харж байгаатай холбоотой байж болох юм.

Зураг 3. Зудын нөхцөл байдлын сургалтад сөргөөр нөлөөлсөн байдал аймгаар, хувиар (багш нарын хариулт)



Сургалтад зудын нөхцөл байдал хэр нөлөөлсөн талаар багш нараас тодруулж асуухад Сүхбаатар аймгийн багш нарын 72.9 хувь нь маш их нөлөөлсөн гэсэн бол Дундговь аймгийн багш нарын 64.8 хувь нь сөргөөр нөлөөлсөн гэж хариулжээ.

Хүснэгт 1.Зудын нөхцөл байдлаас хамаарсан хичээл таслалт, хувиар (багш нарын хариулт)

	Давтамж	Хувь
Маш бага	20	4.5
Бага	22	4.9
Дунд зэрэг	92	20.5
Их	193	43.0
Маш их	118	26.3
нөлөөлөөгүй	4	0.9

Дээрх хүснэгтээс харахад, зудын нөхцөл байдлаас хамаарсан сурагчдын хичээл таслалт их байсан гэж асуулгад оролцсон 3 багш тутмын 1 нь хариулсан нь онцгой нөхцөл байдал, ялангуяа зуд нь сурагчдын хичээлийн ирцэд сөргөөр нөлөөлсөн нь харагдаж байна.

Хүснэгт 2. Регрессийн шинжилгээ, зудын нөхцөл байдлын хичээл сургалтад нөлөөлсөн байдал

Model		Стандарт бус коэффициент		Стандарт коэффициент	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	.752	.424		1.773	.087
	Таны бодлоор зудын нөхцөл байдал нь сурагчдын хичээл	.689	.118	.736	5.855	.000


сургалтад хэрхэн
нөлөөлсөн бэ?

a. Dependent Variable: Зудын нөхцөл байдлаас хамаарсан хичээл таслалт ямар байсан бэ?

Дээрх хүснэгтээс харахад, зудын нөхцөл байдал нь сурагчдын хичээл таслалтад нөлөө үзүүлэх тусам хичээл таслалт ойролцоогоор 0.7 нэгжээр нэмэгдэж байна.

Хэрэв хичээлийн таслалт байсан бол аль ангийн ирц хамгийн ихээр буурсныг тодруулахад ойролцоогоор 2 менежер тутмын нэг нь дунд ангийн хүүхдүүд гэж хариулсан байна. Мөн бага ангид таслалт байсныг 4 менежер тутмын нэг нь онцолсон байна.

Зураг 4. Хичээлийн таслалт ангиар, хувиар



Харин сурагчид ойролцоогоор хэд хоног хичээлдээ ирэхгүй байсныг багш нараас тодруулахад, 3-5 хоног гэж 32.0 хувь нь хариулсан бол 6-14 хоног гэж 44.0 хувь нь хариулжээ.

Хүснэгт 3. Сурагчдын хичээлд ирээгүй хоног, хувиар

		Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	3-5 хоног	141	31.4	31.5	31.5
	6-10 хоног	101	22.5	22.5	54.0
	11-14 хоног	95	21.2	21.2	75.2
	15-аас дээш хоног	51	11.4	11.4	86.6
	1 сар	48	10.7	10.7	97.3
	1 улирал	12	2.9	2.9	100.0
Total		448	100.0		

Сурагчдын ярилцлагаас ч ийм дүр зураг харагдлаа. Ярилцлагын явцад сурагчид хичээлдээ дунджаар 7-14 хоног ирж чадаагүйгээ дурдсан байна.


Би 7 хоног хичээлээ ирж чадаагүй, цаснаас болж зам хаагдсан.

Би бас бараг 14 хоног болчихсон, хичээлдээ ирж чадаагүй.

Сумын сургуулийн бага ангийн сурагчидтай хийсэн ярилцлагаас


Сурагчдын хичээлдээ ирээгүй хугацаа нь аймгийн хувьд статистик ач холбогдлын түвшинд ялгаатай байна ($p < 0.001$). Сүхбаатар аймгийн сурагчид харьцангуй олон хоног хичээлд ирээгүй буюу 14-өөс дээш хоног хичээлдээ ирээгүй сурагчдын тоо олон гэж судалгаанд хамрагдсан багш нарын 40.6 хувь нь хариулжээ.

Зураг 5. 14 хоногоос дээш хугацаагаар сурагчдын хичээлдээ ирээгүй байдал, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Хичээлдээ ирэхгүй байсан сурагчдын хүйсийг багш нар болон нийгмийн ажилтнаас тодруулахад, эрэгтэй хүүхдүүд хичээлдээ ирэхгүй байх нь давамгайл байжээ.

Зураг 6. Хичээлд ирээгүй сурагчдын хүйсийн харьцаа, хувиар



Малчин айлын эрэгтэй хүүхдүүд хичээлдээ ирэхгүй байсан нь илүү анзаарагдсан. Чөлөө авч байгаа хүүхдүүд ч гэсэн малчин айлын эрэгтэй хүүхдүүд байх нь их.

Сумын сургуулийн нийгмийн ажилтны ярилцлагаас


Судалгаанд хамрагдсан багш нарын хариултаас харахад, сурагчид зам даваа хаагдсаны улмаас эсвэл гэр бүлдээ туслах хүнгүйгээс шалтгаалаад хичээлдээ ирэхгүй байжээ.

Хүснэгт 4. Хичээлдээ ирэхгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар

	Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	Зам даваа хаагдах	135	30.1	30.1
	Сургуульдаа ирэх унаагүй	108	24.1	54.2
	Гэр бүлдээ туслах	173	38.5	92.9
	өвдсөн	32	7.3	100.0
Total	448	100.0	100	

Багш нарын дээрх хариулт нь аймгийн хувьд статистик ач холбогдлын түвшинд ялгаатай байна ($p < 0.01$).

Зураг 7. Сурагчдын хичээлдээ ирээгүй шалтгаан, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Дээрх зургаас харахад, Сүхбаатар аймгийн 77.0 хувьд зам даваа хаагдах, сургуульдаа явах унаагүйн улмаас сурагчид хичээлдээ ирэх боломжгүй байсан бол Баянхонгор аймгийн 56.0 хувь, Дундговь аймгийн 48.9 хувьд гэр бүлдээ туслах хүнгүйгээс хичээлдээ ирээгүй нь илүү байсан байна.

Тодорхой хугацаагаар хичээлдээ ирээгүй сурагчдаас сургууль завсардах тохиолдол байдаг эсэхийг тодруулахад завсардах нэг шалтгаан байж болохыг багш нарын 69.0 хувь нь, цөөн тохиолдолд завсардах шалтгаан болдог гэж 14.0 хувь нь хариулжээ.


Зураг 8. Хичээлд ирээгүй сурагчдын сургууль завсардах магадлал, хувиар
(аймаг тус бүрээр)



Эцэг, эхчүүдтэй хийсэн ярилцлагаас харахад, сумын төвд байдаг айлуудын хувьд цаг агаарын аюулт үзэгдэл, зуд зэргээс шалтгаалан хүүхдийнхээ хичээлийг таслуулсан тохиолдол байхгүй гэсэн ч зарим нэг шалтгаанаар 1-2 өдрийн чөлөө авсан гэж хариулжээ. Харин сумын төвөөс хол байдаг айлуудын хувьд цас их орсон, зам боогдсон зэрэг шалтгааны улмаас хичээлдээ очих боломжгүй болсон тул хичээлийг нь тасалдуулсан, чөлөө авсан гэдгээ тайлбарлан, энэ тохиолдолд анги удирдсан багш, зарим үед сургуулийн захирал, нийгмийн ажилтантай холбогдсон гэсэн байна.

Зудын үед ангиудын дулаан халаалтын систем доголдсоноос цөөнгүй ангиуд хичээллэхэд хүйтэн байсан байна.

Зураг 9. Зудын үеийн нөхцөл байдлын үеийн анги танхимын дулааны байдал, хувиар
(аймаг тус бүрээр)



Аймгийн төвийн сургуулийг бодвол сумын сургуулиуд, аймгаар нь үзвэл Дундговь, Баянхонгор аймгийн сургуулиудын ангиуд нь илүү хүйтэн байсан гэжээ ($p < 0.01$).


1.2. Онцгой нөхцөл байдал/зудын сурагчдын суралцахуйд гарсан бэрхшээл

Суралцахуйд гарч байгаа бэрхшээлийг тодруулахад, хичээлээ ойлгохгүй, өмнө нь үзсэн сэдэв агуулгаа мартах, хичээлээ нөхөх, гэртээ байх хугацаандаа хичээл хийх боломжгүй нь сурахад бэрхшээлтэй байсныг ярилцлагад хамрагдсан сурагчид дурдсан байна. Ялангуяа ийм бэрхшээлийг дунд, ахлах ангийн сурагчид өгүүлсэн нь их байна.

Багш нарын асуулгаас харахад, олон хоног сургуульдаа ирээгүй сурагчид сургуульдаа буцаж ирэхэд анхаарлын төвлөрөл буурдаг болохыг 78.6 хувь нь, ар гэртээ санаа нь зовдог болохыг 32.3 хувь нь, багш болон үе тэнгийнхнээсээ санаа зовдгийг 15.6 хувь нь тус тус дурджээ. Үүнээс шалтгаалан суралцахуйн хувьд хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцох идэвх сулрах, сургалтын агуулгаас хоцрох зэрэг суралцахуйн бэрхшээл үүсдэгийг 86.8 хувь нь онцолсон байна.

Суралцахуйн бэрхшээлтэй холбоотой асуултын тухайд багш нарын хариулт нь аймгийн хувьд ялгаатай байна ($p < 0.001$).

Зураг 10. Суралцахуйн бэрхшээлийн талаарх багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Дээрх зургаас харахад, Сүхбаатар аймгийн багш нарын 91.1 хувь нь сурагчдын хичээлийн идэвх сулрах, сургалтын агуулгаас хоцрох нь нь илүү гэдгийг онцолжээ. Зудын нөхцөл байдлаас шалтгаалаад дотуур байрны хүүхдүүд гэртээ санаа зовох, эцэг эхээ санах зэргээс хамаараад хичээлдээ идэвх сонирхолгүй байсныг дотуур байрны багш нар ярилцлагын үед нэлээд онцолж байсан. Энэ үед нь эцэг, эхтэй нь утсаар яриулах, сэтгэл санааг нь засах гэх мэт арга хэмжээ авч байсан гэжээ. Сургууль сэтгэл зүйчгүй тул нийгмийн ажилтантай уулзуулж зөвлөгөө өгүүлж байсан гэжээ.

Хүүхдүүд хэдийгээр байрандаа ирээд сургуульдаа суух сонирхолтой ч аав минь одоо яаж байгаа бол, ээж минь одоо яаж байгаа бол, өглөө л гараад орой л ирдэг гэж ярин санаашран суух тохиолдол цөөнгүй байсан, заримдаа хичээлээ хийж байгаад юм бодоод суучихдаг. Энэ нь хичээлдээ л анхаарах, даалгавар гүйцэд хийхэд нь саад учруулдаг.

Сумын сургуулийн дотуур байрны багшийн ярилцлагаас

Онцгой нөхцөл байдал, зудын үед тодорхой хугацаагаар хичээлдээ ирж чадаагүй бага, дунд ангийн эмэгтэй сурагчдын хувьд өөртөө итгэлгүй, стресст орсон байдал ажиглагдсан гэж сэтгэл зүйчид хариулсан байна.

1.3. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, арга зүй

Боловсролын ерөнхий хуулийн 27.1.7-д “...гамшгийн улмаас сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийнэ” гэж заасан байна. Үүнтэй холбоотой онцгой нөхцөл байдлын үед сургалтын тасралтгүй байдлыг хэрхэн хангаж байсан талаар сургуулийн захирал, сургалтын менежер, багш нараас тодруулсан.

Зудын нөхцөл байдлын үед сургуулиуд хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж байсан ба ийм үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах төлөвлөгөө сургуулиудад байдаг гэж менежерүүдийн 87.1 хувь нь хариулжээ. Ийнхүү боловсруулахдаа орон нутгийн Боловсролын газартай хамтардаг байна. Харин судалгаанд хамрагдсан 4 сургууль тутмын нэг нь Орон нутгийн онцгой байдлын газартай хамтардаг дүр зураг харагдлаа.

Зураг 11. Төлөвлөгөө боловсруулах үеийн хамтрагч талууд, хувиар



Хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөхдөө улирлаар юм уу, 1 жилийн хугацаатай төлөвлөдөг гэжээ.

Хүснэгт 5. Хичээлийн төлөвлөлтийн хугацаа, хувиар

		Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	Улирлаар	11	35.5	40.7	40.7
	Жилээр	13	41.9	48.1	88.9
	2-5 жилээр	2	6.5	7.4	96.3
	Бусад	1	3.2	3.7	100.0
	Нийт	27	87.1	100.0	
Missing	0	4	12.9		
Total		31	100.0		

Хичээлдээ ирэх боломжгүй сурагчдад зориулсан хичээлийн агуулга нөхөх төлөвлөгөөтэй эсэх талаар тодруулахад сургуулиудад бэлэн төлөвлөгөө байдаггүй, тухайн нөхцөл байдалд тулгуурлан төлөвлөгөө боловсруулах эсвэл хоорондоо зөвлөлдөн ярилцаж ажилладаг гэж дийлэнх захирлууд хариулсан.

“Тухай бүрд нь гаргаж ажилласан. Ирээдүйд болох эрсдэлийг бид бас сайн мэдэхгүй тооцоолоогүй, сургуулийн нэгдсэн төлөвлөгөөг дотор нь задлаад зуд, хаврын салхи шуургатай уялдуулж төлөвлөгөө хийгдэж байна”.

Сургуулийн захиралтай хийсэн ярилцлагаас

Харин зудын нөхцөл байдлын үеийн цахим хичээлийн төлөвлөлтийг ихэвчлэн багш нар тухайн үедээ хийж хэрэгжүүлдэг гэж ярилцлагад оролцсон сургалтын менежерүүд дурдсан байна.

Энэ талаар багш нараас тодруулахад, хичээлдээ ирэх боломжгүй болсон сурагчдад сургалтын агуулгыг тасралтгүй хүргэх талаар хичээл сургалтын төлөвлөгөөг тухайн үедээ боловсруулан мөрддөг гэж 75.0 хувь нь хариулсан. Энэхүү хариулт нь аймгийн хувьд статистик ач холбогдлын түвшинд ялгаатай байна ($p < 0.01$).

Зураг 12. Цахим болон зайн сургалтын төлөвлөгөө тухайн үедээ боловсруулдаг гэж үзсэн багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Дээрх зургаас харахад, Сүхбаатар аймгийн багш нарын 82.0 хувь нь зудын нөхцөл байдлын цахим хичээлийн төлөвлөлтийг тухайн үедээ хийдэг гэжээ.

Арга зүйн хувьд, зудын үед хичээлийг төлөвлөхдөө танхимын болон цахим сургалтын хосолмол арга зүйг тусгасан бөгөөд энэ нь бодитоор хэрэгжих нөхцөл боломж бүрдсэн гэж судалгаанд хамрагдсан сургалтын менежерүүдийн 30.0 хувь нь дүгнэсэн. Харин тусгасан боловч хэрэгжилтийн хувьд техник хангамж дутагдалтай байсан гэж 41.0 хувь нь үзжээ.

Мөн хэдийгээр хосолмол байдлаар хэрэгжүүлэх арга зүйг тусгадаг боловч багш бодит сургалтдаа хэрэгжүүлэх нь сул байсныг менежерүүдийн 30.0 хувь нь үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан 4 менежер тутмын 1 нь цахим сургалтаар хичээл явуулах талаар арга зүйн хэсэгт ерөнхий байдлаар тусгасан, 3 менежер тутмын нэг нь тухайн


арга зүйг тусгасан боловч хэрэгжилтийг сул байсан гэж үзсэн бол 41.0 хувь нь тухайн арга зүйг тусгасныхаа дагуу хэрэгжүүлсэн гэжээ.

Хүснэгт 6. Хичээлийн төлөвлөлтөд туссан арга зүй, хувиар

		Давтамж	Бодит хувь
Valid	Цахим сургалтын арга зүйг ерөнхийд нь дурдаж тусгасан.	7	25.9
	Цахим сургалтын арга зүйг тусгасан боловч тусгасны дагуу хэрэгжилт хангалтгүй байсан.	13	33.3
	Цахим сургалтын арга зүйг ойлгомжтой тусгаж хэрэгжүүлсэн.	11	40.7
Бүгд		31	

Үүнийг багш нараас тодруулахад, цахим болон зайн сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл боломж сул бүрдсэн 41.0 хувь нь үзсэн бол бүрдэж чадсан гэж 26.0 хувь нь дүгнэсэн байна. Иймд цаашид онцгой нөхцөл байдлын хичээл сургалтын бэлэн байдлыг хангахын тулд техник тоног төхөөрөмж, цахим орчны бүрдэлтийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна. Багш нарын тухайн хариулт нь аймгийн хувьд статистик ач холбогдлын түвшинд ялгаатай байна ($p < 0.01$).

Зураг 13. Цахим болон зайн сургалтын явуулах боломж, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Дээрх зургаас харахад, Сүхбаатар аймгийн багш нарын 44.0 хувь нь цахим болон зайн сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл боломж сул бүрдсэн гэж үзсэн бол 27.0 хувь нь бүрдсэн гэж үзсэн байна. Гэтэл Дундговь аймгийн багш нарын 36.0 хувь нь сул бүрдсэн гэж үзсэн бол 32.0 хувь нь бүрдсэн гэж үзжээ.

Зудын үеийн нөхцөл байдлын төлөвлөлтөд сургалтыг чанартай, хүртээмжтэй явуулах арга зүй хэрхэн туссан байдгийг нийгмийн ажилтнаас ярилцлагаар тодруулахад ихэнх нь бараг тусаагүй, сургуулийн төлөвлөгөө бараг байхгүй, багш нар тус тусдаа цахим хичээл явуулах мөн цаасан хэрэглэгдэхүүн тараах байдлаар хичээлийг явуулсан

Гамшгийн төлөвлөгөө байдаг л байлгүй дээ. Нөхцөл байдлаас хамааран хичээл 14 хоног тасарсан. Энд байгаа сумын хүүхдүүдийг цахимаар хамруулж байсан. Хөдөөгийн малчид сургууль хөдлөө гэхэд эцэг эх нь шууд ирээд аваад явсан. Хөдөөгийн малчдын хүүхэд цахимаар ороогүй. Цаасаар даалгавар өгч явуулсан, хүүхдүүд хичээлээ чанартай хийсэн гэхэд хэцүү байна, тэр талаар хэлж чадахгүй нь. Сүлжээний хувьд, сумын төвд ойрхон байгаа бол барина, хол нутаг нь сүлжээ барихгүй.

Сумын сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

бөгөөд энэ нь чанартай хүртээмжтэй байж чадсан нь эргэлзээтэй болохыг дурджээ. Судалгаанд хамрагдсан багш нарын 67.2 хувь нь ангид нь боловсролын тусгай хэрэгцээтэй болон эмзэг бүлгийн хүүхдүүд суралцдаг гэж хариулсан. Гэтэл хичээлийн төлөвлөлтийн арга зүйд үүнийг дурдаад өнгөрөх төдий дүр зураг харагдаж байгаа тул арга зүйг нь нарийн тусгаж хэрэгжүүлэх тал дээр олон талын хамтын ажиллагааг хангаж ажиллах хэрэгтэй байна.

Өнгөрсөн өвлийн зудын үеийн хичээлийн төлөвлөлтөд боловсролын ялгаатай хэрэгцээт болон нийгмийн эмзэг бүлгийн сурагчдын тэгш хамруулах талаар тусгаж хэрэгжүүлдэг гэж сургуулийн менежерүүдийн 37.0 хувь нь, туссан хэдий ч арга зүйг нь сайжруулах шаардлагатай болохыг 41.0 хувь нь үзсэн бол багш нарын 35.0 хувь нь энэ талаар тусгаж хэрэгжүүлдэг, 32.0 хувь нь хааяа хэрэгжүүлдэг гэсэн тоо баримт харагдлаа.


Хүснэгт 7. Хичээлийн төлөвлөлтөд боловсролын ялгаатай хэрэгцээт байдлыг тусгасан байдал, хувиар

		Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах талаарх арга зүйг тусган хэрэгжүүлдэггүй.	1	3.2	3.7	3.7
	Туссан хэдий ч ямар нөхцөлд хэрхэн явуулах нь тодорхой биш.	5	16.1	18.5	22.2
	Тэгш хамруулах талаарх заасан ч арга зүйг нь сайжруулж тусгах шаардлагатай.	11	35.5	40.7	63.0
	хүүхдийг тэгш хамруулах талаарх арга зүйг тусгаж хэрэгжүүлдэг.	14	45.2	37.0	100.0
Бүгд		31	100.0		

Иймд онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлтөд боловсролын ялгаатай хэрэгцээтэй болон нийгмийн эмзэг бүлгийн суралцагчдыг тэгш хамруулах талаар дурдаад өнгөрөх биш арга зүйг нь нарийн тусгаж хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Сургуулиуд хичээлийн төлөвлөлтөд хүүхдийн бие даан суралцах арга зүйг тодорхой хэмжээгээр тусгадаг нь багш нарын асуулгын үр дүнгээс харагдлаа.

Зураг 14. Хичээлийн төлөвлөлтөд сурагчдын бие даасан байдал туссан байдал, хувиар



Оролцооны хувьд, багш нарын 25.9 хувь нь суралцагчдыг төлөвлөлтийн дагуу бүрэн хичээлд хамруулсан гэсэн бол 56.0 хувь нь заримыг нь оролцуулж чадсан гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 8. Зудын нөхцөл байдлын үед сурагчдыг хичээлд бүрэн оролцуулсан байдал, хувиар

	Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid				
Бараг үгүй	2	6.5	7.4	7.4
Хааяа	3	9.7	11.1	18.5
Заримдаа	19	48.4	55.6	74.1
Тогтмол	7	35.5	25.9	100.0
Бүгд	31	100.0		

Харин сурагчидтай хийсэн ярилцлагаас харахад, багш нь цахимаар, утсаар холбогдож дасгал даалгавар өгсөн хэдий ч сүлжээгүй байсан, хичээл давтах завгүй байсан, хичээл хийх боломж орчин нөхцөл байхгүй байснаас хичээлийг хийж чадаагүйгээ дурджээ. Эцэг эхчүүд ч мөн адил хүүхдүүд нь хичээл хийх зав боломжгүй байсныг ярилцлагад дурдсан байна. Ийм учраас зудын үед сурагчдын хичээлийн оролцоо хангалтгүй байжээ гэсэн дүр зураг харагдаж байна. Багш нарын хувьд цахимаар болон утсаар холбогдож дасгал даалгавар өгөх эсвэл цаасан хэвлэмэл хэрэглэгдэхүүн илгээснээр суралцагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцуулсан гэж үзсэнээс дээрх үр дүн харагдаж байж болох талтай.

1.4. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны хамтын ажиллагаа

ЕБС-иудад орон нутгийн зүгээс ямар дэмжлэг тусалцаа үзүүлдэг талаар тодруулахад “Сургууль хамгийн олон хүнтэй байгууллага учир ямар ч тохиолдолд хамтран ажиллаж дэмжиж ажилладаг. Зарим үед материаллаг зүйл дээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.” гэсэн хариулт голлож байлаа.

“Бид нар зуд жоохон онгойгоод ирэхээр нь сэтгэл зүйч авч сумдаар орсон. Тэгсэн Халзан сумын хүүхдүүд гэртээ очиход хамгийн хэцүү байсан эцэг, эх нь ууртай гэрийн уур амьсгал хэцүү байсан гэж ярьж байсан. Харин 3-р улирлын амралтаар очиход арай дээр болчихсон инээж хөхрөөд л гэж ярьж байсан даа бас л их зүйл хэлж байсан хүүхдүүд. Малчдад бол тусламжууд их ирж байсан тэрийг малчид хүүхдүүддээ зарцуулаагүй, өөрсдөдөө зарцуулаагүй малдаа л зарцуулсан. Малаа яаж нэгийг ч гэсэн авч үлдэх вэ гэдэгт л анхаарч байсан. Мөнгө гэхээс илүү сэтгэл зүйн дэмжлэг илүү хэрэгтэй л харагдаад байгаа”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Тодорхой хугацаанд хичээлдээ ирж чадаагүй сурагчдад хэрхэн тусалж байсан тухайд сургуулиудаас ирц авч тамгын газрын хариуцсан мэргэжилтнүүдэд үйл ажиллагааны чиглэл өгдөг дүр зураг харагдлаа. Хоцорсон хүүхдүүдийг хагас бүтэн сайнд хичээллүүлэх, чөлөөт цагаар нь хоцрогдлыг арилгах чиглэл сургуулиудад өгдөг байна. Цас зудтай үед хүүхдийг гэрт нь хүргэж өгөх авах эсэх талаар аюулгүй байдлыг хангах, болгоомжтой байх талаар орон нутгийн хурал дээр ярилцдаг аж.

Хүүхдийг хүргэж өгөх талаарх асуудлыг ямар унаагаар авч хүргэж өгөх талаар хурал дээр асуудал болгон оруулж байсан ч эцэг эхчүүд нь өөрсдөө ирээд авчихдаг гэж сургуулийн захиргаанаас хэлж байсан. 2-3 удаа энэ талаар ярьж байгаад больсон асуудал байгаа. Сум орон нутагт хандан сургуулиас хүсэлт орон нутагтаа тавих юм бол хүүхдийг аюулгүй хичээл сургуульд нь авчрах асуудлыг шийдвэрлэж болно.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

“зудаас болж хичээлдээ ирж чадахгүй юм байгаагүй. Замаа гаргасан учраас ирж чадаагүй хүүхдүүд байгаагүй. Яагаад сургууль руугаа явсангүй вэ гэдэг асуудлыг багийн дарга нар бидэнд бас мэдэгддэг. Тэгээд бид нар эцэг эхтэй нь холбогдоод асуухад бензин шатахуун байсангүй тэгээд хүргэж чадсангүй гэх тохиолдлыг хэлж байсан. Баг сургууль хоёрын хооронд 20-50 км-ийн зайтай байгаа. Шилжилт хөдөлгөөн нь хүн амын тоо, нийгмийн хамгаалал талын асуудал хөндөгдөж байна. Багшийн дутагдал сумын сургуульд дутагдалтай учраас эцэг эх аймаг руу явуулах сонирхолтой байдаг. Чадварлаг багшийг суманд ажиллуулахад төрөөс анхаарах хэрэгтэй”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Онцгой нөхцөл байдлын үед сургуулиудад хичээл тасалдал харьцангуй бага байсан гэж засаг дарга нар ярьж байсан. Учир нь зуд нь сурагчдын амралтын үеэр таарсан ч

эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл сургуулийг тасалдуулахгүйн тулд өөрсдөө ямар нэгэн байдлаар сурагчдыг дотуур байранд нь авчирч өгч байсан. Цөөн тохиолдолд зудаас шалтгаалан зам даваа хаагдсан сургуульд ирэх боломжгүй байгаа малчин өрхийн сурагчдыг орон нутгийн унаагаар очиж авсан гэж ярьсан байна.

ОБГ-ын мэргэжилтний 90.0 хувь нь зуд болон онцгой нөхцөл байдлын үед дэмжлэг туслалцаа үзүүлж аймаг, сумын ЗДТГ, эрүүл мэндийн байгууллага, сургуультай хамтран ажилладаг хэмээн хариулсан байна.

Боловсролын газраас сургуулийн удирдлага болон багш нарт зудын улмаас хичээлдээ ирэх боломжгүй болсон сурагчдад хичээлийн агуулгыг нөхөх талаар зөвлөн тусалсан байна.

... ЗДТГ-т сэтгэл зүйч ажиллах шаардлагатай байна. Малчид зудад малаа алдаад сэтгэл санаагаар унах, хямрах байдал хавар хүчтэй илэрч дэмжлэг шаардлагатай болдог.

Сумын Засаг даргын ярилцлагаас

Хичээлд ирээгүй сурагчдын эцэг, эхтэй багш нар хэр хамтарч ажиллаж, хичээлийн хоцрогдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг эцэг эхчүүдээс ярилцлагаар тодруулахад анги удирдсан багштай утсаар ярьж чөлөө авсан дүр зураг л харагдаж байна.

Хичээл, сургалт тасалдсан үед эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хичээлийг давтуулах, нөхөх тал дээр хэрхэн ажилладгийг тодруулж асуухад “хичээл давтуулах зав муу, боломж байгаагүй, даалгавраа хийгээрэй, хичээлээ нөхөөрэй, давтлага аваарай гэх мэтээр сануулдаг” гэсэн хариултыг ихэнх нь өгсөн байна.

Даалгавар аваад очсон байсан ч давтуулах зав байгаагүй. Энэ жил өвөлжилтийн байдал их хүнд байсан. Бид малтайгаа ноцолдож байгаад л өдөр өнгөрнө. Бараг хүүхэд ч гэртээ орох завгүй байсан. Хичээл номыг хийлгэх ямар ч боломж байгаагүй.

Эцэг эх, асран хамгаалагчтай хийсэн ярилцлагаас


Зарим эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхэд нь эмээ өвөөгийнхөө, эсвэл ээжтэйгээ сумын төвд өвөлжсөн тул хичээл тасалдаагүй, гэр бүлийн гишүүд нь гэрийн даалгавар хийхэд нь тусалж байсан тухай дурдсан байна. Мөн хичээлээ, даалгавраа бие дааж хийдэг тухай хэлсэн байна.

Мөн онцгой болон зудын нөхцөл байдлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд багш нар хоорондоо хамтарч ажиллах, харилцан туршлагаа солилцох талаар тодорхой тусган энэ нь сайн түвшинд хэрэгждэг талаар судалгаанд хамрагдсан сургуулийн менежерүүдийн 59.0 хувь нь дүгнэсэн бол 37.0 хувь нь дунд зэрэг гэж үзсэн байна. Ер нь, энэ талаар хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд тусдаг талаарх дүр зураг асуулгад оролцогч менежерүүдийн хариултаас харагдаж байна.

Онцгой нөхцөл байдал, зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагаанд багш, эцэг эх ба хүүхдүүдийн 3 талын хамтын ажиллагааны төлөвлөлт хэрэгжилтийг сайжруулахад анхаарах нь зүйтэй байна. Ойролцоогоор 62.0 хувь нь энэ талын хэрэгжилтийг сул байсан гэж үнэлжээ.

Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны үүргийг тодорхой хэмжээгээр тусгасан дүр зураг харагдлаа.

Зураг 15. Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны оролцоо, хувиар



Нийгмийн ажилтны ярилцлагаас харахад, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид:

- Сурагчдыг сэтгэл санааны хувьд, дэмжих, зөвлөх
- Нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын төлөвлөгөө гаргаж ажиллах.
- Зудын нөхцөлд байгаа сурагчдын талаарх мэдээллийг цуглуулах
- Зудын нөхцөлд байгаа сурагчдад хэвлэмэл хичээлийн хэрэглэгдэхүүн хүргэж өгөх зэргээр хамтарсан дүр зураг харагдлаа.

Нийгмийн ажилтан бид нар хүүхдийн мэдээ авах багш нартай хамтрах байдлаар хүүхдүүдийн мэдээ гаргаж байсан. Хүүхдүүд интернэт орчинд байгаа бол багштайгаа холбоо бариад байсан, тэд нарыг хаана хэдэн км цаана байна яаж байна гээд аль болох холбоо барих гэж хичээсэн. Бүүр холбоогүй хүүхдүүдийг бол онцгойтой хамтраад тараах материал өгөх замаар шийдэх гэж хичээж байсан. Даалгавар багш явуулж байсан. Эндээс унаа явж таарвал хэвлэмэл хичээл хүргүүлж байсан. Бага ангийн хүүхдүүдийн хувьд цаасан материал өгч явуулж байсан даа. Сүүлд 4 хүүхэд үлдээд улирлын амралтын дараа ирсэн. Сэтгэл зүйчтэйгээ хамтраад хичээл яаж таслуулахгүй байх талаас нь, зам нь онгойсон уу гэх зэргээр мэдээлэл авч ажилласан.

Сумын нийгмийн ажилтны ярилцлагаас

Мөн сургуулийн сэтгэл зүйчтэй сургуулийн тухайд, зудын үед гэртээ байсан хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг өгөх талаар төлөвлөдөг боловч шаардлагатай хүүхдүүдийг тухайн үед нь бүрэн хамруулж чадаагүй гэж хариулсан байна. Харин хүүхдүүдийг сургуульдаа ирэхэд нь хүлээн авч уулзаж зөвлөгөө өгсөн талаар дурджээ. Тэрчлэн гэртээ байсан сурагчдаас дэлгэцийн хамааралтай болох эрсдэлтэй сурагчдын судалгаа авсан ба судалгааны үр дүнд тулгуурлан анги удирдсан багш

болон сурагч, эцэг эхчүүдэд зөвлөгөө дэмжлэг үзүүлж хамтран ажилласан дүр зураг харагдлаа.

Сургалтын менежерүүдийн 52.0 хувь нь сургуулийн эсвэл орон нутгийн эмч, эмнэлгийн байгууллагын үүргийг тусгасан байдал, түүний хэрэгжилтийг дунд зэрэг гэж үнэлжээ. Иймд хичээлийн төлөвлөлт арга зүйдээ онцгой нөхцөл байдлын төрлөөс нь хамааруулан төлөвлөлтөд дурдсан субъектуудын оролцоог оновчтой тусгах, хамтран ажиллах талаарх мэргэжил арга зүйн дэмжлэгийг сургуулиудад үзүүлэх хэрэгцээтэй байна.

Хүснэгт 9. Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд орон нутгийн эмнэлгийн байгууллагын оролцоо туссан байдал, хувиар

	Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	Сул	1	3.2	3.7
	Дунд зэрэг	1	45.2	51.9
	Сайн	10	32.3	37.0
	Маш сайн	6	19.4	7.4
	Бүгд	27	87.1	100.0
Total	31	100.0		

Хичээлдээ ирэх боломжгүй болсон сурагч, эцэг эхтэй утсаар мэдээлэл өгөх байдлаар харилцаж байсан гэж судалгаанд хамрагдсан багш нарын 56.8 хувь нь үзсэн бол сумын/багийн дарга нараар дамжуулан харилцаж байсан гэж 36.5 хувь нь үзжээ.

Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд сургууль нь бусад байгууллага болон эцэг эхтэй хамтран ажилладаг уу гэсэн асуултад ажилладаг гэж багш нарын 75.9 хувь нь хариулсан байна.

Байгалийн гамшигт үзэгдэл болох талаар багш ажилтан, сурагчдад сургуулийн зүгээс хэрхэн сэрэмжлүүлж анхааруулга өгдөг үйл ажиллагааг нийгмийн ажилтнуудаас тодруулахад дараах дүр зураг харагдлаа.

- Онцгой байдлын газраас сургуулиудад мэдээлэл хүргэхэд багш нар ихэвчлэн ангийн эцэг эхчүүдийн чат группээр дамжуулан мэдээллийг тогтмол хүргэдэг ч эцэг эхчүүд 100 хувь мэдээлэл авдаггүй байна.
- Сургуулийн нэгдсэн группэд мэдээллийг байршуулах, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид эцэг эхчүүд, сурагчид руу утсаар ярьж мэдээллийг хүргэдэг тал байна.
- Сургуулийн пэйж хуудаст мэдээллийг байршуулдаг байна.
- Сумын ус, цаг уур болон онцгой байдлын газар сумын группүүдэд мэдээлэл тавихад сурагч, эцэг эхчүүд мэдээллийг хүлээж авдаг байна.

БШУ газраас, сумын онцгой байдлаас сэрэмжлүүлгийг байнга өгдөг, үүнийг цахим болон утсаар сурагч, эцэг эхчүүдэд мэдээлэл тогтмол хүргэдэг. Мөн ангийн группээр дамжуулан мэдээллийг өгдөг. Манай аймаг шуурга их болно энэ үед анги удирдсан багштай хамтран хүүхдүүдээ сургуулиас ирж авах үед гараас гарт өгч хэвшсэн.

Сумын сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

1.5. Зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны хэрэгжилт

Зудын нөхцөл байдлын үед хичээл сургуульдаа ирж чадаагүй сурагчдад багш нар сургалтын цаасан болон цахим хэрэглэгдэхүүн илгээж хичээлийн агуулгаас хоцруулахгүй арга хэмжээг авчээ.

Зураг 16. Онцгой нөхцөл байдлын үед багш нарын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хувиар



Сургалтын цаасан хэрэглэгдэхүүний хувьд, дасгал ажлын дэвтрийг хэвлэж өгч байжээ. Мөн цөөнгүй багш нар ном сурах бичгээс даалгавар өгч байсан байна.

“Цаасан даалгавар өгч байсан. Анги удирдсан багш нар сурагчдын асран хамгаалагч нартай холбогдож хичээл ном гэхээсээ илүүтэй эрсдэл үүсэхгүй байх тал дээр мэдээлэл хүргэсэн. Цаг агаарын нөхцөл байдал болон малын араас хүүхэд явуулахгүй байх тал дээр анхааруулга өгч байсан. Зудын үед сурагчдын ар гэрийн нөхцөл байдал болон хэрэгцээтэй зүйлсийн талаар тодруулах болон зарим тохиолдолд анги удирдсан багш нар сурагчдын ар гэрээр явж нөхцөл байдалтай танилцаж, малын хэвэг тэжээл болон хоол хүнс хүргэж өгсөн.

Сургуулийн захиралтай хийсэн ярилцлагаас

Мөн хичээлдээ ирэх боломжгүй сурагчдад хэрхэн хичээлээ нөхөх талаар зөвлөгөө туслалцаа өгч ажилласан эсэхийг багш нараас тодруулахад, ганц 2 удаа өгч байсан гэж 34.8 хувь нь хариулсан бол 1-2 өдөр өнжөөд өгч байсан гэж 33.3 хувь нь, өдөр бүр гэж 22.3 хувь нь хариулжээ.

Хүртээмжтэй чанартай байдлыг бий болгох гол арга зам нь ирсний нь дараа нэмэлт давтлага өгөх, дотуур байранд нь давтлага өгөх гэх мэтээр хичээлийн агуулгын хоцрогдлыг нөхөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал зарим нэг сургуулийн хувьд байна. Энэ тохиолдолд багш нарыг үндсэн ажлыг нь хийлгэхгүйгээр давхар ажлаар ачаалах нь хичээлийн агуулгын хоцрогдолд орсон сурагчтай ажиллахад хүндрэл

Манайх хичээлийн хоцрогдолтой хүүхдүүдээ ялгаж аваад сургууль дээр мөн дотуур байрны хүүхдүүдэд багш нар очиж цагаар давтлага өгсөн. Бүр ирж чадахгүй байсан 3 сурагчдаа эндээс материал бэлдэж ойр хавийх нь айл руу явуулсан. Тамгын газраас багшийн үндсэн ажлыг хийлгэхгүй зарах гээд байдаг. Гэхдээ аль болох давтлага өгүүлэхийг боддог. Гэхдээ л энэ асуудал сайн шийдэгдэхгүй байна.

Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

учруулдаг тал харагдлаа.

Багш нарын хувьд сурагчдыг тодорхой хугацааны дараа хичээлдээ ирэхэд, хичээлээс гадуур нэмэлт цагаар давтлага өгч ажиллахдаа тогтмол биш гэж 42.0 хувь нь хариулсан бол 1-2 хоног зарцуулсан гэж 20.5 хувь нь, өдөр бүр гэж 20.5 хувь нь тус тус үзжээ.


Хүснэгт 10. Сурагчдад нэмэлт давтлага өгсөн байдал, хувиар

		Давтамж	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Valid	Огт хийгээгүй	19	4.2	4.2	4.2
	цөөн	57	12.7	12.7	17.0
	1-2 хоног	92	20.5	20.5	37.5
	заримдаа	188	42.0	42.0	79.5
	өдөр бүр	92	20.5	20.5	100.0
	Бүгд	448	100.0	100.0	

Эндээс харахад, хичээлийн хоцрогдлыг арилгах тал дээр нэмэлт давтлага өгөх арга хэмжээг сургууль, багшийн зүгээс хэрэгжүүлсэн боловч төдийлөн үр дүнтэй байсан гэж дүгнэх боломжгүй байна.

Багш нарын энэхүү хариулт нь аймгийн хувьд статистик ач холбогдлын түвшинд ялгаатай байна ($p < 0.001$).

Зураг 17. Сурагчдад нэмэлт давтлага өгч байсан давтамж, багш нарын хариулт, хувиар (аймаг тус бүрээр)



Дээрх зургаас харахад, Сүхбаатар аймгийн багш нар 1-2 өдөр өнжөөд өгөх нь нөгөө 2 аймгийн багш нараас харьцангуй илүү бол Баянхонгор, Дундговь аймгийн хувьд хааяа өгдөг гэсэн хариулт нь илүү байна.

Мөн сургуулиудын хувьд, зудын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар сурагч, эцэг эх, асран хамгаалагчдаас судалгаа тогтмол авч хэвшээгүй байна. Энэ нь нэг талаас сургуулиуд онцгой нөхцөл байдлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны бэлэн байдалд дадаагүйтэй, нөгөө талаас гэнэтийн нөхцөл байдал нь нөлөөлсөн байх бүрэн боломжтой юм.

Сэтгэл ханамжийн судалгаа аваагүй, харин сургуулийн сэтгэл зүйч уулзаж зөвлөгөө өгсөн. Тэр үеийн нөхцөл байдал сэтгэл ханамжийн судалгаа авахаар тийм нөхцөл биш, хүнд байсан, хүүхдүүд санаа зовох зүйл ихтэй, жишээлбэл, малтай үлдсэн болов уу? мал хөлдсөн болов уу гэх мэт сэтгэл санааны хувьд тогтворгүй байсан. Тэгээд судалгаа аваагүй, уулзаж ганцаарчлан зөвлөгөө өгч байсан даа.

Сумын сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Сургуулийн зүгээс онцгой нөхцөл байдлын үед хичээл сургалтаас завсардах эрсдэлтэй сурагчдын судалгаа хийж, хариу арга хэмжээ авах нь сурагчдын хичээлийн агуулгаас хоцрох, сургууль завсардах эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой юм.

“7-р ангийн нэг хүүхэд сургууль завсардсан байсан, эцэг эхтэй нь уулзаж эргүүлж сургуульд нь оруулсан”. Хичээл таслалт, завсардалт байхгүй, хүүхдийн араас маш сайн хөөцөлддөг, шилжилт хөдөлгөөнд хатуу байдаг, хүүхдийн тоогоор сургууль оршин тогтож байна. 1-р ангид сурч байгаа хүүхдийн прогнозыг авч судалгаан дээр ажиллана. 50-аас дээш хүүхэд орвол хэвийн явагдана гэсэн үг. Мэргэжлийн багшийн цаг зөрөөд багшийн тоо цөөрнө.

Сургуулийн захиралтай хийсэн ярилцлагаас

2024 оны өвлийн зудын үеийн тухайн нөхцөл байдлыг нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаар тодруулахад сургуулиас завсардах магадлалтай сурагчдын судалгааг хийдэг байна. Сурагчдын сургуулиас завсардахад нөлөөлөх эрсдэл бүхий хүчин зүйл

нь нэгдүгээрт, ар гэрийн хүн бүл муутай байх, энэ тохиолдолд ихэвчлэн дунд ангийн хүүхдүүд завсардах магадлалтай байна, мөн хөгжлийн бэрхшээлтэй байдал, эцэг, эх нь ажлын байрны олдоцоос хамаараад өөр аймаг, сум руу шилжсэнээс болоод хүүхдүүд дунд нь завсардах тохиолдол байна. Олон биш ч гэсэн гэр бүлийн хараа хяналтгүй, гэр бүлийн хүчирхийлэлтэй нөхцөлд амьдардаг хүүхдүүд сургуулиас завсардах эрсдэлтэй байна. Сүхбаатар аймагт хүүхдүүд хурдны морь унах нэрийдлээр хичээл таслах нь нэг эрсдэлт хүчин зүйл болдогийг судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнууд дурджээ.

Сургууль завсардах үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа анги удирдсан багшаас гадна орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг, багийн засаг дарга нартай хамтран ажилладаг дүр зураг харагдлаа.

1.6. Онцгой нөхцөл байдлын үеийн сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Хичээлд ирэхгүй байгаа сурагчдын хичээлийн хоцрогдлоос урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авахад сургууль, багш нарт тулгамдаж буй гол бэрхшээл нь эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоо, идэвхгүй байдал байна.

Зураг 18. Тулгамдаж байсан асуудал, хувиар



Багш нарын хувьд хичээлийн агуулгыг нөхөх нь ачаалал үүсгэдэг байна.

Манайд илүү их эрсдэлтэй хүүхдүүд байдаг гэж хэлж болно, учир нь малчдын хүүхдүүд ихтэй, архины хамааралтай гэр бүлд байгаа хүүхдүүд ихтэй, аймагтаа хамгийн захын сургууль болохоор эрсдэл ихтэй гэр бүлүүд олон байдаг. Ийм гэр бүлүүд хүүхдийнхээ хичээлийг их таслуулна.

Аймгийн сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Онцгой нөхцөл байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагаанд ихээр тулгамддаг асуудлыг нийгмийн ажилтнуудаас тодруулахад, цахимаар хичээл ороход сурлагын хоцрогдол үүсэх эрсдэлтэй байсан байна. Ийнхүү цахимаар ороход, үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас эсвэл сүлжээ барих боломжгүй байдлаас болоод хичээлдээ оролцох нь хангалтгүй байжээ. Энэ нь зудын нөхцөл хүндэрсэн Сүхбаатар

аймагт илүү тохиолдсон байна. Мөн сурагчдын амралтын урт хугацаа нь зудын хүнд нөхцөл байдлын үетэй зөрөөд байгаа нь хүндрэлтэй тул зохицуулалт хийж болох талаар эцэг, эхчүүд нэлээд санал тавьдаг гэжээ.

Сэтгэл зүйн дэмжлэг сурагчид төдийгүй эцэг эхэд ч бас хэрэгтэй гэж харагдаж байна. Мөн зудаас шалтгаалаад хүмүүсийн бие өвдөж байна, мал нь үхээд ирэхээр үнэхээр хэцүү байдал үүссэн. Жишээлбэл, 10 настай, 1-р ангид сурдаг 2 хүүхэдтэй, 50 гаруй үхрээ үхүүлсэн айл байна. Малын араас харамсах хэцүү байдал гэр бүл, хүүхдүүдэд үүсээд байна. Амьдралын эх үүсвэргүй болохоор хүүхдээ яаж тэжээхээс эхлээд сэтгэл зүйн хүнд асуудалд ордог. Энэ нь хүүхдэд ч бас нөлөөлнө.

Сумын сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Мөн зудын нөхцөл байдлын үед дотуур байранд биш гадуур айлд байдаг сурагчдын хувьд үүсдэг нэг том бэрхшээл нь тухайн айл нь хөдөө мал руугаа явах болсноор асран хамгаалалт, хараа хяналтгүй байдал үүсэх, эрсдэлт нөхцөл болдгийг нийгмийн ажилтнууд онцолсон байна.

Сэтгэл зүйчдийн хувьд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, чиглүүлэг хангалтгүй байсныг дурдсан байна. Мөн анги удирдсан багш болон судлагдахууны багш нарын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй, суралцагчдын хичээлийн идэвх, хандлага нь сул байсан гэжээ.

Сурагчдын хувьд, хичээлээ ойлгохгүй, хичээлээ нөхөж чадахгүй гүйцэхгүй болох, сэтгэл санаа тогтворгүй болох, багшаасаа айж эмээх, багш нарын дэмжлэг туслалцаа сул байх, их ядрах зэрэг бэрхшээл үүссэн байна. Ялангуяа ийм бэрхшээлийг дунд, ахлах ангийн сурагчид дурджээ.

Найзуудаасаа л хичээлээ асууж нөхөж авахыг хичээсэн. Энэ тал дээр багшаас асуудаг хэдий ч багш нарын туслалцаа сул байдаг, ангийнхнаасаа асуу, өөрсдөө нөх гэж хэлдэг.

Хичээл даалгавраа багшаас аваагүй байсан учир их айж байсан.

Дунд, ахлах ангийн сурагчидтай хийсэн ярилцлагаас

Эцэг эхчүүдийн хувьд тулгамдаж байсан асуудал: Тодорхой бэрхшээл байхгүй гэж ярилцлагад хамрагдсан эцэг эх нийтлэг хариулсан ба ямар ямар дэмжлэг

Хоцрогдол хамгийн их үүссэн. Коюидын үеийн хүүхдүүдийн хоцрогдол одоо ч арилаагүй, хоцрогдол ихтэй байгаад байна. Ялангуяа 3, 6, 7-р ангийн хүүхдүүд одоо ч хоцрогдолоос гарч чадаагүй л яваал байна. Энэ ийм сул тал ихтэй байгаа тул зудын үед цахимаар хичээл ороход сурлагын хоцрогдол зайлшгүй үүсдэг. Өөрөөр хэлбэл, цахим хичээлийг хүүхдүүд хийхгүй байна. Үүнээс болоод хичээлдээ дургүй болдог, мөн ар гэртээ санаа зовох, хичээлдээ анхаарахгүй тал байна.

Сургуулийн захиралтай хийсэн ярилцлагаас

шаардлагатайг тодруулахад, Орон нутгийн засаг захиргааны байгууллага сургуультай хамтран хүүхдийн хичээл сургалтыг тасалдуулахгүй тал дээр нэгдсэн арга хэмжээ авахыг нийтлэг хэлсэн. Жишээлбэл, зам давааны цас арилгаж зам гаргах, хүүхдийг нь нэгдсэн унаагаар сургуульд хүргэж өгөх гэх мэт. Мөн урт хугацааны улирын амралтыг зудын үеийн нөхцөл байдал үүсэх, хавар цагийн ид ажлын үеийг харгалзан тохируулга хийдэг байх зэргийг дурдсан.

Дотуур байрны багш нарын хувьд тулгамдаж байсан асуудал:

- Эцэг эхчүүд хүүхдээ сургууль руу нь замын хүнд дайх зэргээр эцэг эхийн хайхрамжгүй хариуцлагагүй байдал бэрхшээлтэй талаар дурдсан байна.
- Дотуур байрны хүүхдүүдийн хичээлийн агуулгыг нөхөх тал дээр бусад судлагдахууны багш нартай хамтарч ажиллах нь бэрхшээлтэй байдлыг үүсгэж байсан байна.
- Хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх тал дээр сургуулийн сэтгэл зүйчгүй тул бэрхшээл үүсгэж байсныг дурджээ.

Хүүхдүүдийн сэтгэл санааны байдал нэлээд тогтворгүй болдог. Нэмээд хавар болоод мал төллөөд ирэхээр мал нь зутарсан ажил ихтэй аав ээж нь ирэхгүй, өөрсдөө очиж чадахгүй болохоор сэтгэл санаа нь бүр тогтворгүй болдог юм. Тэгээд 4-р сард амралтаараа очоод ирэхдээ огт амарч чадсангүй ядарлаа гэсээр л ирдэг.

Сумын дотуур байрны багш

Цаашид зудын нөхцөл байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг сайжруулах тал дээр ямар санал байгааг засаг дарга, сургуулийн захирал болон нийгмийн ажилтнуудаас тодруулахад дараах саналуудыг хэлсэн байна.

Засаг дарга нарын хувьд:

- Орон нутгийн онцлогт тохируулан малчдын хүүхдийн сурагчдын амралтын хуваарийг өөрчлөх (*хавар 3-4-р сард урт амардаг байх*)
- 3-р улирлын амралтыг орон нутаг өөрсдөө зохицуулдаг байх
- Орон нутагт хамран сургах тойрог уялдахгүй байгаа тул хамран сургах тойрог заахгүй байх
- Суманд сүлжээ муу байдаг болохоор гэнэтийн аюулын үед сургуульдаа ирж чадаагүй хүүхдүүд цахим орчинд хичээллэх боломжийг бүрдүүлэх

Сургуулийн захирлуудын хувьд:

- Сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах, халаалт, сантехникийн
- Хичээлд зохицуулалт хийх эрх мэдлийг шилжүүлэх
- Гамшгийн сантай болох
- Намрын улиралд хүнсээ нөөцөлдөг болох (*мах, ногоо*)

- Харилцаа холбоог сайжруулах
- Нөхцөл байдалд уялдаатай ажлын төлөвлөгөөтэй байх
- Эцэг эхийн сэтгэл зүйг бэлтгэх (*бага насны хүүхдийг далимдуулж авч явахгүй байх, хичээл таслуулахгүй, сурлагын хоцрогдолд оруулахгүй байх*)

Нийгмийн ажилтнуудын хувьд:

- Сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөнд гамшгийн нөхцөл байдлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг оруулах
- Онцгой байдлынхантай хамтын ажиллагааг сайжруулах
- Сургууль бүрд сэтгэл зүйч ажиллуулах (*ингэснээр зудын нөхцөлд байдалд ороод ирсэн сурагчид, ар гэртээ санаа зовох, хичээлийн хоцрогдлоос шалтгаалан санаа зовох, стресс түгшүүртэй нөхцөлд сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээг үзүүлэх нь чухал юм.*)
- Сургууль орон нутгийн хүүхэд хамгааллын багтай хамтарч ажиллаж, эцэг эхчүүдэд хүүхдээ хамгаалах талаар зөвлөн туслах
- Сургуулийн зүгээс эцэг эхчүүдийн хүүхдийн суралцахуйг дэмжих чадварыг нь сайжруулахад анхаарч ажиллах
- Сургууль дээр хичээлээс гадуурх үйл ажиллагааг нэмэгдүүлж сурагчдын оролцоог сайжруулах (*Ингэснээр хүүхэд сургуульдаа дуртай байх нэг нөхцөл болж өгнө.*)
- Малчдын хүүхдүүдийн өвлийн урт хугацааны амралтыг өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлаас хамааран орон нутаг зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх
- Зуд гамшгийн нөхцөл байдал хүндэрсэн үед гэртээ харж хандах хүнгүй үлдсэн сурагчдыг тодорхой хугацаанд дотуур байранд суулгах

ХОЁР. СУРГУУЛИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Гамшгаас хамгаалах тухай хууль” -ийн 8.1-д ... “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”. Мөн хуулийн 8.3-д ...”гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална” гэж заасан байна. Үүний дагуу сургууль нь гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан аймаг, сумын ЗДТГ-ын албаар батлуулдаг байна.

Мөн хуулийн 3.1-д “...гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ” гэж тус тус заасан байна.

Иймээс бид судалгаанд хамрагдсан сургуулийн онцгой байдлын үед ажиллах “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд баримт бичгийн шинжилгээ хийлээ.

2.1. ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт

Орон нутгийн засаг даргаас онцгой нөхцөл байдлын үеийн орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаар тодруулахад орон нутаг Онцгой нөхцөл байдлын үеийн сургуулийн бэлэн байдлын төлөвлөлтийг Аймгийн онцгой комисс гаргадаг бөгөөд мэргэжлийн байгууллагууд тус тусдаа гаргаж нэгтгэдэг байна. Төлөвлөгөөг тухайн жилийнхээ цаг үеийн нөхцөл байдал, гамшигт үзэгдэлд тулгуурлан жил бүр тодотгол хийдэг. *(Жил бүр өөр өөр талаас нь тодотгол хийгдэж нэмэгдэж сайжирч байдаг)*. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь нууцын зэрэглэлтэй байдаг.

“Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд Боловсролыг яаж тасалдалгүй явуулах талаар нэг ч үг өгүүлбэр тусгагддаггүй”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн орон нутгийн байгууллагын дарга нар бүгд ордог учир уялдаатай боловсруулдаг. Шуурхай штабын бүрэлдэхүүнд сургуулийн захирал байдаг. Сургуулийн захирал бусад байгууллагын төлөвлөгөөг холбох үүрэгтэй ажилладаг.

“ЕБС-ийн асуудлыг гамшгийн төрлөөр гаргах нь зөв гэж үзэж байна. ЕБС-ийн гамшгийн төлөвлөгөөнд гамшигт аюулт үзэгдлээс хамгаалах сургалтыг тусад нь оруулж, сургалт явуулах шаардлагатай гэж үзэж байна. Зудын үед амралт сунгах асуудлыг аймгийн онцгой байдлын газар шийддэг”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Төлөвлөгөөг сургууль онцгой байдлын газраас өгсөн загварын дагуу боловсруулж сургуулийн багш ажилтангуудаа ажлын хэсэгт хуваарилж үүрэгжүүлдэг байна. Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сургууль дангаараа боловсруулдаг бөгөөд мэргэжлийн талаас онцгой байдлын газар, практик талаас ЗДТГ, ЕБС харилцан хамтран боловсруулах шаардлагатай байдаг.

Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2021-2022 онуудад боловсруулсан бөгөөд орон нутгийн онцлогоос хамааран 2-4 жилийн давтамжтай үйл ажиллагаанаас хамаараад нэмж хасаж тодотгол хийдэг байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар засаг дарга нараас тодруулахад, Хэрэгжилт харилцан адилгүй байх бөгөөд тухайн орон нутгийн онцлогоос хамааран төлөвлөгөөнд туссан ажлуудаас хэрэгжих ажил ч байна хэрэгжихгүй үлддэг ажил ч бас байдаг. Төлөвлөгөөний хэрэгжилт төсвийнхөө хүрээнд өвс тэжээл нөөцлөх, техник тоног төхөөрөмж авах, сайжруулах гэх мэт материаллаг талруу голдуу чиглэж ажилладаг. “Хүүхэд хөгжил хамгаалал талаар хэрэгжилт байдаггүй” гэж хариулсан байна.

Орон нутгийн урт хугацааны төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийг бууруулах талаар тусгадаг эсэх талаар тодруулахад оролцогчдын дийлэнх нь байгалийн гамшиг гэнэт тохиолддог тул тусгах боломжгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд суралцагчдыг гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн хүүхэд хамгаалал талаар тусгагдсан байдлын талаар тодруулахад энэ чиглэлийн заалт тусгагдсан гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь хариулсан байна. Төлөвлөгөөнд энэ чиглэлийн 5-10 заалт тусгагддаг байна.

“Суманд хүүхэд хамгаалах баг байдаг ерөнхий төлөвлөгөөг сургууль барьж явна. Шадар сайдын тушаалаар байгууллага бүр эрсдлээс хамгаалах төлөвлөгөөтэй байна гэсэн тэр шугамаар бас хүүхэд хамгаалах хүүхэд хамгааллын баг үйл ажиллагаагаа сайн хийж байдаг. Энэ нь сургуулийн үйл ажилтай холбоотой явагдаад хоорондоо дандаа л уялдаатай явуулах гэж хичээнэ”.

Засаг даргатай хийсэн ярилцлагаас

Орон нутгийн төсөвт сургуулийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулах төсөв байдаг эсэх талаар засаг дарга нараас тодруулахад – “Гамшгаас хамгаалах хуультай уялдуулаад сумдад доод тал нь 20 сая төгрөг тусгаж бай гэж чиглэл өгсөн. Үүний

хүрээнд орон нутгийн гамшгийн эрсдэлийн санд жилд дунджаар 10-15 сая төгрөг төсөвлөгдөж орж ирдэг. Тэрнээс ЕБС-д орон нутгаас тусгах төсөв байдаггүй” шаардлагатай тохиолдолд засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэх боломжтой, зарим тохиолдолд иргэдийн хурлаас тодорхой хэмжээний зардал оруулж асуудлаа шийддэг гэж судалгаанд оролцогчид хариулсан.

Орон нутагт гэнэтийн онцгой нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээ авах талаар бэлэн төлөвлөгөө байдаг эсэх талаар тодруулахад-Засаг дарга нарын дийлэнх нь тухайн нөхцөл байдалд тулгуурлан ажил үүргийн зураглал гаргаж хуваарилалт хийдэг гэж ярьсан. “Сургуульд сурч байгаа үед нь байгалийн гамшиг гарах үед авах хариу арга хэмжээг нарийн тусгасан төлөвлөгөө гаргах нь чухлыг Засаг дарга нар онцолж байсан. Хүүхдийг сэтгэл зүйгээр яаж дэмжиж байх вэ гэдэг асуудлыг зохицуулахыг төлөвлөгөөндөө тусгах шаардлагатайг мөн дурдсан байна.

Төлөвлөгөөг илүү боловсронгуй болгож сайжруулахын тулд сургуулиуд дараах арга хэмжээг тусгах нь зүйтэйг Засаг дарга нар онцолжээ.

- Байгалийн гамшиг гэнэтийн зүйл болохоор гэнэт тохиолдвол бэлэн байх талаас төлөвлөгөөгөө сайжруулах,
- Бодлогын түвшинд төлөвлөгөөгөө сайжруулах, хэрэгжилт дээр хяналт тавих
- Төлөвлөгөөндөө гэнэтийн аюулын талаар нарийвчлан тусгадаг болох

2.2. ЕБС-иуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулсан эсэхэд хийсэн шинжилгээ

Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хүртээмж, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх судалгааны хүрээнд Баянхонгор аймгийн Галуут (1), Жаргалант (2), Бөмбөгөр (16), Сүхбаатар аймгийн Баруун-Урт (17), Эрдэнэцагаан (8), Мөнххаан (6), Дарьганга (9), Онгон (10), Дундговь аймгийн Эрдэнэдалай (12), Сайхан-Овоо (13), Хулд (14) сумдын ерөнхий боловсролын сургуулиудын гамшгаас хамгаалах нийт 11 төлөвлөгөөнд шинжилгээ хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар” нь 5 бүрэлдэхүүн хэсэг, 8 хавсралтаас бүрддэг ба энэ төлөвлөгөөний загварыг үндэслэл болгон загварын дагуу боловсруулсан эсэхийг харьцуулан шинжиллээ.

Онцгой нөхцөл байдлын үеийн ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинжилгээ хийхдээ төлөвлөгөөний загварын дагуу боловсруулсан байдал, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэмээх 2 үзүүлэлтийн хүрээнд баримт бичгийн шинжилгээг гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 11. “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу боловсруулсан эсэхэд хийсэн шинжилгээ /аймгаар, сумдаар/

Бүрэлдэхүүн хэсэг		Нийтлэг үндэслэл	Танилцуулга	Гамшиг, ослоос урьдч/сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээ төлөвлөгөө	Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө
Баянхонгор	1	-	-	+	+	-
	2	-	+	+	+	-
	3	+	+	+	+	-
Сүхбаатар	4	-	-	+	-	-
	5	-	-	+	-	-
	6	-	-	+	-	-
	7	-	-	+	-	-
	8	-	-	+	-	-
Дундговь	9	-	+	+	+	-
	10	-	-	+	-	-
	11	-	-	-	-	-

Эх сурвалж* Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан аймаг, сумдын ерөнхий боловсролын сургуулиудын 91.0 хувь нь “Нийтлэг үндэслэл” хэсгийг, 72.0 хувь нь “Танилцуулга” хэсгийг, 9.0 хувь нь “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах” төлөвлөгөөг, 64.0 хувь нь “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г, бүх сургууль “Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө”-г тус тус боловсруулаагүй байна.

Нийтлэг үндэслэл хэсэгт: “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу төлөвлөгөөний зорилго, төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим, төлөвлөгөөний хамрах хүрээ, удирдлага зохион байгуулалт гэсэн 4 хэсгээс бүрдэж байна.

Нийтлэг үндэслэл хэсгийг боловсруулсан Баянхонгор аймгийн “3” сумын ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээг тусгаж, баримтлах зарчмыг огт тусгаагүй байна. Удирдлага зохион

байгуулалт хэсгийг нийтлэг үндэслэл хэсэгт оруулаагүй, тусад нь “Гамшгаас хамгаалах орон тооны бус зөвлөл, бүлгийн бүрэлдэхүүний томилгоожуулалт” гэсэн нэршлээр оруулан дотор нь “Орон тооны бус зөвлөлийн гүйцэтгэх үүрэг”, “Орон тооны бус бүлгийн гүйцэтгэх үүрэг”, “Орон тооны бус бүлгийн тусгай гүйцэтгэх үүрэг” хэмээн 3 баг болгон авч үзсэн нь аль нь мэргэжлийн ангийн гүйцэтгэх үүрэг болох, орон тооны бус зөвлөл, бүлэг хоёрын ялгаа нь юу болох, бүлгийн гүйцэтгэх үүрэг, тусгай гүйцэтгэх үүрэг хоёрын ялгаа нь юу болох зэрэг нь тодорхойгүй, ойлгомжгүй байна. Төлөвлөгөөний загварын дагуу авч үзвэл, “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг”, “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг үүрэг” гэж 2 хуваан авч үзсэн байдаг байна.

Танилцуулга хэсэгт сургуулийн байршил хаяг, барилга байгууламжийн ерөнхий зохион байгуулалт, хүчин чадал, эрсдэлийн удирдлагын чадавхын үнэлгээг авч үздэг байна. Манай судалгаанд хамрагдсан сургуулиуд дээрх үзүүлэлтүүдээс эрсдэлийн удирдлагын чадавхын үнэлгээг хийлгээгүй, бусад үзүүлэлтүүдийг бүрэн тусгасан байна. Харин сургууль дээр тохиолдож байсан гамшгийн сургамж, дүгнэлт үзүүлэлтүүдийг багтаан авч үзсэн байна. Энэ хэсэгт Баянхонгор аймгийн “2” сумын ерөнхий боловсролын сургууль “Сургууль дээр гамшгийн тохиолдол байгаагүй” гэж үзсэн бол “9” сумын сургууль “дулааны шугам хөлдөх”, “малчид ихээр отор нүүдэл хийж хүүхэд сургууль завсардах”, түр шилжин суух, алслагдсан оторт хүүхэд хүргэх, “1” сумын сургууль дулааны шугам сүлжээ гэмтэх, нийт албан хаагчдын 80 хувь нь эмэгтэй, өндөр хүчдэлийн шон ойрхон, сургуулийн орчны 50 метр дотор автомашины замтай, нийт сурагчдын 50-иас дээш хувь нь 10 хүртэл насны, 20 хувь нь тавиул хүүхэд байгаа нь байгууллагын гамшгийн эмзэг байдал гэж үзсэн байна. Эмзэг байдалд үндэслэн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, эмзэг байдлаа хэрхэн саармагжуулах талын арга хэмжээ тусгагдаагүй байна.

Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө нь доорх хүснэгтэд тусгагдсаны дагуу төлөвлөгөөний зорилго, үр нөлөө, чиглэл тус бүрээр арга хэмжээ, түүний үр дүнгийн болон чанарын шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацаа, тухайн арга хэмжээ тус бүрээр шаардагдах төсвийг тусгадаг байна.

Хүснэгт 12. “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г загварын дагуу боловсруулсан байдал

Шалгуур								
Сумын сургууль	Үр нөлөө	Чиглэл	Арга хэмжээ	Үр дүнгийн, чанарын шалг/үз-лт	Хэрэгж-ийг хариуцах эзэн	Хамтр/хэрэгж-х байг-лага	Хэрэгжих хугацаа	Шаард/төсөв
1	-	-	+	+	+	+	-	-
2	-	-	+	+	+	-	+	-

16	-	-	+	-	+	+	+	-
17	-	-	+	-	+	+	+	-
8	-	-	+	-	+	-	+	-
6	-	+	+	-	+	-	+	-
9	-	-	+	-	+	-	+	-
10	-	-	+	-	+	-	+	-
12	-	-	+	-	+	+	+	-
13	-	-	+	-	+	+	-	-
15	-	-	+	-	+	-	+	-

Эх сурвалж* Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар дахь ”Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-ний бүтэц

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиуд нь төлөвлөгөөг бүтцийн дагуу боловсруулсан эсэхэд шинжилгээ хийж үзэхэд төлөвлөгөөний зорилго, үр нөлөө, шаардагдах төсвийг огт тусгаагүй, харин хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах эзнийг 100 хувь тусгаж, нийт судалгаанд хамрагдсан сургуулиудын 9 хувь нь чиглэлийг, 18 хувь нь үр дүнгийн болон чанарын шалгуур үзүүлэлтийг, 45 хувь нь хамтран хэрэгжүүлэх байгууллагыг тусган боловсруулсан байна.

Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө нь доорх хүснэгтэд өгөгдсөн бүтэцтэй байдаг байна. Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиуд “Хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Хугацаа”, “Хариуцах албан тушаалтан” гэсэн бүтцийн дагуу боловсруулсан байна.

Хүснэгт 13. Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний бүтэц

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Багтаамж	Хугацаа			Хариуцах албан тушаалтан
		Минут	Цаг	Хоног	
Жнь: Ажилтан, албан хаагчдад гамшиг аюулын тухай зарлан мэдээлэл хүргэх					

Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний хугацааг төлөвлөгөөний загвараар бол цаг, минут, хоногоор нарийвчлан тусгадаг байна.

Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь доорх хүснэгтэд өгөгдсөн бүтэцтэй байгаа ба энэхүү бүтцийн дагуу сургуулиуд боловсруулаагүй байна.

Хүснэгт 14. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний бүтэц

№	Байгууллагын дэргэдэх аюулгүй талбай	Талбайн хэмжээ	Бүртгэл явуулах албан тушаалтан /нэр, утасны дугаар/	Аюулгүй талбайд байрших ажилтан албан хаагч, сурагчид	Бүртгэлийн нэгдсэн мэдээ гаргах албан тушаалтан /нэр, утасны дугаар/	Тайлбар

Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө 8 хавсралттай байхаас судалгаанд хамрагдсан сургуулиудын 2 нь гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч, холбоо зарлан мэдээллийн схемтэй, 1 сургууль гамшгаас хамгаалсан

мэргэжлийн анги байгуулсан тушаал, хүч хэрэгсэл нөөцийн судалгаа, ажлын зургийг хавсаргасан байна.

Хүснэгт 15. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-ний хавсралт, аймаг, сумдаар

д/д	Хавсралт	Баянхонгор			Сүхбаатар					Дундговь		
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Гамшгаас хамгаалсан мэргэжлийн анги байгуулсан тушаал	-	-	-	-	-	-	-	-	+	-	-
2	Ажлын тусгай горимд шилжих тушаалын төсөл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч	-	-	-	-	+	-	-	-	+	-	-
4	Холбоо зарлан мэдээллийн схем	-	-	-	-	+	-	-	-	+	-	-
5	Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа	-	-	-	-	+	-	-	-	-	-	-
6	Ажлын зураг	-	-	-	-	+	-	-	-	-	-	-
7	Ажлын тусгай горимд шилжих, ажиллах төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Үйл ажиллагааны тогтвортой ажиллагааны төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Хавсралтын 38-50 хувийг төлөвлөгөөнд хавсаргасан бол үлдсэн 6 сургууль ямар ч хавсралтгүй байна.

Судалгаанд хамрагдсан сургуулиуд батлагдсан бүтэцийн дагуу төлөвлөгөөг боловсруулаагүй, бүтцийн зарим хэсгийг боловсруулаад зарим хэсгийг орхисон, бүтцийн бүрэлдэхүүнд байх хэсгийг тусад нь бүлэг болгон оруулсан, төлөвлөгөөний бүтцийн зарим бүрэлдэхүүн хэсгийн нэршлийг өөрөөр нэрлэсэн зэрэг нь шинжилгээнээс харагдлаа. Иймээс цаашид ерөнхий боловсролын сургуулиуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулахад маш тодорхой дэмжлэг хэрэгтэй байна.

2.3. Ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ түүнд хийсэн шинжилгээ

Ерөнхий боловсролын сургуулиуд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулахдаа “Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн өмнөх, үеийн, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааны хүрээг хамруулсан байна. “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд

“Гамшгийн өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах бэлэн байдлын төлөвлөгөө” гэх зэргээр олон янзаар нэрлэж байна.

Бид шинжилгээг хийхдээ хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Байгууллагын төлөвлөгөөний загвар”-ыг үндэслэн бүлэглэн ангилсан болно. Төлөвлөгөө боловсруулахын тулд сургууль, дотуур байрны эрсдэл, эмзэг байдлын болон чадавхын үнэлгээнд тулгуурлах байтал ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээ хийх арга хэмжээг огт төлөвлөөгүйгээр арга хэмжээнүүдийг тусгасан байдал харагдлаа. Сургуулиуд төлөвлөгөөг боловсруулахдаа батлагдсан загварын дагуу бус хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, хариуцах эзэн, хамтран хэрэгжүүлэх байгууллага гэсэн 3 хүрээнд боловсруулсан нь нийтлэг байна.

Гамшгийн өмнөх үйл ажиллагаа: “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө” нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан загвараар төлөвлөгөө зорилго, үр нөлөө, чиглэл тус бүрээр авах арга хэмжээ, түүний үр дүнгийн болон чанарын шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацаа, шаардагдах төсөв гэсэн бүтэцтэй хэдий ч сургуулиуд хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, хариуцах эзэн, хамтран хэрэгжүүлэх байгууллага гэсэн хүрээнд боловсруулсан нь нийтлэг байна.

Арга хэмжээний хувьд: Судалгаанд хамрагдсан сургуулиудын 4 чиглэлийн хүрээнд давхардсан тоогоор нийт 25 арга хэмжээг төлөвлөсөн байна. Гамшгаас хамгаалах хуулинд гамшгийн өмнөх үйл ажиллагааны хүрээнд 1) гамшгийн эрсдэлийг үнэлэх, 2) хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, 3) хамгаалах бэлэн байдлыг хангах, 4) хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх, 5) хамгаалах сургалт сурталчилгаа зохион байгуулах, 6) мэдээллээр хангах, эрсдэлийг бууруулах, 7) мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг 7 чиглэлийг багтаан авч үздэг байна. Үүнээс эрсдэлийн үнэлгээ хийлгэх, хяналтыг хэрэгжүүлэх чиглэлийн арга хэмжээ тусгагдаагүй байна. Хуулийн 8.1-д зааснаар Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх ажлын хүрээнд байгууллага гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна гэж үзсэн байдаг. Иймээс 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг багцлан харуулбал доорх байдалтай байна.

Хүснэгт 16. Гамшгийн өмнө хэрэгжүүлэх арга хэмжээ

Чиглэл	Гамшгийн өмнө хэрэгжүүлэх арга хэмжээ
Дэд бүтцийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх	- Сургуулийн хэмжээнд өвлийн бэлтгэлийг хангах, түлээ түлш, хоол, хүнсний нөөц бүрдүүлэх - Өвөлжилтийн нөхцөл байдлын судалгааг гаргах, хариуцсан мэргэжилтнүүдэд 7 хоног бүр мэдээллэх

	- Цаг агаарын хэт хүйтрэлт, хүчтэй салхи шуурганы улмаас барилга байгууламжид гэмтэл учрах, цахилгааны эх үүсвэр тасалдах болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх - Ердийн галлагаатай барилга байгууламжид галын аюулгүй байдлыг сахих, харуул хамгаалалтын ажилтны хариуцлагыг сайжруулах, хяналт тогтмол тавих - Өвөлжилт хаваржилтийн бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, өвс тэжээл, хужир шүү нөөцлөх ажлыг эрчимжүүлэх - Эрчим хүчний найдвартай тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх\нөөц цахилгаан үүсгүүртэй болох\
Гамшигт нэрвэгдэж болзошгүй хүүхдийн бүртгэл, мэдээллийн сан үүсгэх	- Эрсдэлт бүлгийн хүүхдийн бүртгэл, судалгааг нарийвчлан гаргах (Эцэг эх, асран хамгаалагчтай холбогдох хаяг, арга хэлбэрийг тодруулах, холбоотой байх, үнэн зөв мэдээлэлтэй байх, байршлыг тогтоох) - Анги удирдсан багш нараар дамжуулан бүрэн хяналтад авах эцэг, эх, гэр бүлтэй нь холбоотой ажиллах
Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах	- Байгууллагын хэмжээнд гамшгийн үеийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах журам, төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах - Хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлж ажиллах бэлэн байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гаргах - Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг шинэчлэх
Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах	- Багш ажилчид, нийт албан хаагчдад зудын гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалт, ухуулга сурталчилгаа зохион байгуулах - 3 үгт хаягаар байршил тодорхойлох сургалтыг ОБГ-тай хамтран зохион байгуулах - Мэргэжлийн байгууллагаас гаргасан үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийн дагуу сургуулийн хэмжээнд аюулгүй байдлаа хангах сургалт, сурталчилгаа зохион байгуулах - Гамшгийн бэлэн байдлын шуурхай ажиллагааны үед ажиллах группийг гаргаж үйл ажиллагаанд оролцуулах

Дээрх хүснэгтээс харахад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах чиглэлийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.3-т заасан сурагчдад зохион байгуулах сургалтын талаар тусгаагүй байна. Зөвхөн 13.2.4-т заасан ажилтны сургалтыг өөрөөр хэлбэл, “багш, ажилчид, албан хаагч”-дад зохион байгуулна гэж тусгасан байна. Орон нутагт бий болсон нөхцөл байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан мэдээлэлд үндэслэн сургалт, сурталчилгааны чиглэлийг тодорхойлно гэж бичжээ. Тиймээс сургалтын чиглэлийг төлөвлөгөөнд тодорхой гаргаагүй байдал нийтлэг “гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалт”, “Зудын гамшгаас хамгаалах сургалт”, “Зудын гамшгаас урьдчилан сэргийлэх талаар ухуулга сурталчилгаа хийх” зэргээр ерөнхий байдлаар тусгажээ. Харин Сүхбаатар аймгийн “6” сумын төлөвлөгөөнд “3 үгт хаягаар байршил тодорхойлох” сургалтыг ОБГ-тай хамтран зохион байгуулах” гэж тодорхой нэрлэж, тусгасан байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.24 -д гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, ... дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг бэлэн байдлыг хангах гэж үзсэн байна. Тиймээс боловсрол нь нэг талаар дэд бүтэцдээ хамаарч, нөгөө талаар нийгмийн тогтвортой

байдлыг хангах үйл ажиллагаанд хамаарч байгаа юм. Энэ хүрээнд “хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах журам боловсруулах”, “төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах” зэргээр баримт бичиг боловсруулах арга хэмжээг тусгаж өгсөн байна. Гамшигт үзэгдэл болж онцгой нөхцөл байдал үүсэх үед албан бус зайнаас цахимаар сургалт явуулах, сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүн боловсруулах, албан бус хэлбэрээр сурч буй агуулгыг бусад хичээлийн агуулгатай интеграцчилах сургуулийн түвшний сургалтын хөтөлбөрийг боловсруулах зэрэг бодит нөхцөл байдал үүсэхэд авч болох хариу арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 14.2.2, 14.2.1-д заасан гамшигт нэрвэгдэж болзошгүй эрсдэлт бүлгийн сурагчид, тэдний эцэг эхийн бүртгэл, газар зүйн байршил, судалгааг гаргах талаар төлөвлөгөөнд тусгасан байна. Үүнд: “дотуур байранд болон хамаатны айлдаа байдаг сурагчдын бүртгэл”, “аймгийн төвөөс алслагдсан сумдын хүүхдүүдийн судалгаа”, “эцэг эх, асран хамгаалагчтай холбогдох хаяг, утасны дугаар, арга хэлбэр”, “байршил” зэргээр ерөнхий тусгасан байна. Харин аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөн дэх хүн амын бүртгэл мэдээллийн маягттай харьцуулан үзэхэд суурин газрын болон хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын бүртгэлийн талаар сургууль төлөвлөгөөндөө тусгаагүй байна.

Дэд бүтцийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх чиглэлийн хүрээнд сургууль, дотуур байрны дэд бүтцийн тасралтгүй ажиллагааг хангах, тэсвэрлэх нөхцөлийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байдаг. Монгол Улсын Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.10, 3.1.11-д заасан инженерийн болон нийгмийн дэд бүтцэд хамаарах сургууль, дотуур байрны цахилгаан эрчим хүч, дулаан, барилга байгууламжид учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд түлээ түлш, хоол, хүнсний нөөц бүрдүүлэх, эрчим хүчний найдвартай тасралтгүй ажиллах нөөц цахилгаан үүсгүүртэй болох зэрэг арга хэмжээг тусгасан байна. Харин хүүхдийг тээвэрлэх унаа, сургууль дотуур байрны цэвэр бохир усны талаарх арга хэмжээг тусгаагүй ба дэд бүтцийн аюулгүй байдлын шаардлага стандартыг хангах чиглэлээр арга хэмжээг төлөвлөөгүй дүр зураг сургуулиудад нийтлэг байна.

Сүхбаатар аймгийн “6” сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгавал зохих үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна. Чиглэлийг тодорхойлсон байдлыг үзэхэд “хичээл сургалтын тасралтгүй байдлыг хангах чиглэлээр” 7 арга хэмжээ, “Сургалтын орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр” 6 арга хэмжээ, “хүүхэд хамгааллын чиглэлээр” 5 арга хэмжээг тус тус төлөвлөжээ.

Баянхонгор аймгийн “1”, “2” сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгавал зохих үр дүнгийн болон чанарын шалгуур үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт гэсэн нэршлээр доорх байдлаар тусгасан байна.

Хүснэгт 17. Шалгуур үзүүлэлт хэсэгт тусгасан үйл ажиллагаа

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах хүн, ажлын хэсэг, байгууллага
	Сургуулийн орчин, дотуур байрны гар угаах орчин нөхцөлийг сайжруулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, Зарцуулсан санхүүжилт	ЕБС-ийн захиргаа	ЕБС-ийн шуурхай штаб Гамшгаас хамгаалах зөвлөл

Эх сурвалж* Баянхонгор аймгийн “1” сумын ЕБС-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 18. Шалгуур үзүүлэлт хэсэгт тусгасан арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
	Сурагчид, албан хаагчдад гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Жилийн турш	Гамшгийн үед ажиллах анхан шатны мэдлэг олгох	Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн

Эх сурвалж* Баянхонгор аймгийн “2” сумын ЕБС-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Эндээс үзэхэд ямар үр дүнд хүрэх нь бүрхэг, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг хэмжих боломжгүй, энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр өмнө байснаас ямар ахиц өөрчлөлт гарч ямар түвшинд хүрэхийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт болж чадахгүй байна. Шалгуур үзүүлэлт нь тодорхой үр дүнд хүрэхийн тулд хэмжиж болохуйц, биелэгдэх боломжтой, хэрэгцээ шаардлагад нийцсэн, тодорхой хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байхаар боловсруулбал хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг бодитой хийх боломжтой болох юм.

Гамшгийн үеийн үйл ажиллагаа: “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г “Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж нэрлэсэн байгаа нь нийтлэг байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд: Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед 4 чиглэлийн хүрээнд давхардсан тоогоор нийт 37 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байна. Гамшгийн үеийн үйл ажиллагаанд хуулиараа 1) харилцаа холбоо · зарлан мэдээллийг зохион байгуулах, 2) голомтын бүсийг тогтоох, 3) эрэн хайх · аврах, 4) хүч хэрэгсэл дайчлан гаргах · нүүлгэн шилжүүлэх, 5) гамшгийн хор уршгийг арилгах 5 чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнээс голомтын бүсийг тогтоох, эрэн хайх аврах, 2 чиглэлийн арга хэмжээ сургуулийн төлөвлөгөөнд хамааралгүй байна. Гамшгийн хор уршгийг арилгах чиглэлд салбарын тогтвортой байдлыг хангахтай холбоотой боловсролыг дэмжих, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, дэд бүтэцтэй холбоотой арга хэмжээнүүдийг багтаан авч үзлээ.

Хүснэгт 19. Гамшгийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээ

Чиглэл	Гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ
Зарлан мэдээллийг зохион байгуулах	- Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг боловсролын байгууллагын багш ажилтан, сурагч, эцэг эх асран хамгаалагчдад тогтмол хүргэх - Нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, орон гэр, гэр бүлийнх нь талаар онцгой байдлын байгууллага, эцэг эх сурагчдад үнэн бодит мэдээллээр хангах - Суралцагч улирлын амралт, нийтээр амрах өдөр хөдөө явах тохиолдолд дулаан хувцаслах, техникийн аюулгүй байдал хангасан тээврийн хэрэгслээр зорчих - Зөвшөөрөгдөөгүй, эрсдэлт замаар явах, шар усны үер, цөмөрч болзошгүй гол мөрөн, нуур гатлахгүй байх талаар сургуулийн удирдлагууд эцэг эх асран хамгаалагч, олон нийтэд тодорхой давтамжтай мэдээлэл, сэрэмжүүлэг өгөх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах
Гамшгийн хор уршгийг арилгах	- Сургууль, дотуур байрны барилга байгууламжийн халаалтын хэвийн ажиллагааг хангах үүднээс дулаан алдагдлыг тогтмол хэмжих, хомсдол үүсэхээс сэргийлэн түлшний нөөцийг тодотгох, шаардлагатай хариу арга хэмжээг авах, орон нутгийн онцгой комисст шуурхай мэдээлж холбоотой ажиллах - Сургууль, дотуур байрны цахилгаан, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа доголдохоос сэргийлэх хариу арга хэмжээ авах - Байгууллагын тогтвортой ажиллагааг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх - Цас зудад нэрвэгдсэн малчдын нэр, байршлыг нарийвчлан гаргаж, тэдэнд дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах Боловсролыг дэмжих үйлчилгээ үзүүлэх 7 - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах хэсэгт тодотгол хийх - Цахим болон хэвлэмэл сургалтын хэрэглэгдэхүүнийг гэрийн эргэлтээр болон харилцаа холбооны сувгуудаар хүргэх ажлыг зохион байгуулах - Цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан хичээл сургалтын үйл ажиллагааг танхимын болон цахим зайн хосолсон хэлбэрээр зохион байгуулах - Суралцагчдын ирцийн мэдээг өдөр бүр үнэн зөвөөр тодорхой цагт оруулах Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх 16 - Дотуур байр болон гадуур амьдарч буй малчин өрхийн болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд чиглэсэн хүүхэд хамгаалал, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлж, удирдлага арга зүйгээр хангах - Малчдын хүүхдэд чиглэсэн эд материалын дэмжлэг үзүүлэх (хичээлийн хэрэглэгдэхүүн, хувцас) аян зохион байгуулах - Зам даваа хаагдан зорчих боломжгүй болж хичээл сургуульдаа ирж чадахгүй хоригдсон эрсдэлт бүлгийн сурагчдын мэдээллийг нэрчлэн гаргаж, БШУГ, сумын онцгой комисст хүргүүлэх, татан авах ажлыг үе шаттайгаар шуурхай авч хэрэгжүүлэх - Дотуур байрны сурагчид болон айлд суудаг сурагчдыг эцэг эх, асран хамгаалагчгүйгээр замд гарах, хээр хөдөө явуулахгүй байхыг анхааруулах - Дотуур байрны сурагчдын аюулгүй байдлыг хангах - Сургуулийн дотуур байранд нэмэлт эргүүл жижүүр томилон ажиллуулах, - Гамшгийн үед байгууллагын хариуцлагатай жижүүрийг тогтмол ажиллуулах

Хүч хэрэгсэл дайчлан гаргах нүүлгэн шилжүүлэх	- Сургуулийн орчинд мөн дотуур байрын орчинд аюулгүй талбайг томилгоожуулж тэмдэгжүүлэх “Цуглах цэг”-ийг бий болгох
---	---

Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээнд инженерийн дэд бүтэц, байгууллагын тогтвортой ажиллагаа, нэрвэгдэгчдэд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаа гэсэн 4 чиглэлийн арга хэмжээг тусгасан байна.

Гамшгийн дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хуулиараа “Хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаа” гэж нэрлэсэн бол сургуулиудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж нэрлэсэн байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 21-д 1) нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах, 2) дэд бүтцийг сэргээн босгох 2 чиглэлтэй байна гэж үзсэн байна.

Үүнээс дэд бүтцийг сэргээн босгох чиглэлийн хүрээнд арга хэмжээ огт тусгаагүй байна. Хэдийгээр энэ нь сургуулийн хүчин чадлаас үл хамаарч сум сургуулийн түвшинд шийдэх боломжгүй ч сайжруулах хэрэгцээг гарган тавих нь тухайн түвшний байгууллагын үүрэг юм. Харин нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах чиглэлийн хүрээнд давхардсан тоогоор 7 арга хэмжээг тусгасан ба нийт арга хэмжээний 88 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20. Гамшгийн дараа хэрэгжүүлэх арга хэмжээ

Чиглэл	Гамшгийн дараа хэрэгжүүлэх арга хэмжээ
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	- Сургуулийн нөхцөл байдлын тайлан мэдээг гаргаж мэргэжлийн байгууллагад хүргүүлэх
Нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах	Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх - Зудын эрсдэлд өртсөн малчдын хүүхдүүдэд сэтгэл санааг тайвшруулах нөлөөллийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах
	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх 1 - Онцгой нөхцөлд хүүхэд, залуусын цагийг үр дүнтэй, бүтээлч өнгөрүүлэхийг уриалж, холбогдох байгууллагуудыг оролцуулан хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг бэлтгэн цахим хуудсанд байршуулан ажиллах
	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх 2 - Сургууль хичээллэхгүй болсны улмаас бага насны хүүхдийг харгалзах хүнгүй үлдээх, үл хайхрах байдал болон болзошгүй эрсдэлд өртүүлэхээс урьдчилан сэргийлж ажиллах - Эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг, хариуцлага, хүүхдэдээ тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн заавар, зөвлөмжийг хүргэж ажиллах
	- Дотуур байр, үдийн цайны хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нөөцийг бүрэн хангаж ажиллах - Дулааны улиралд мал, амьтны гаралтай халдварт өвчин гарах эрсдэл өндөр тул халдваргүйтэл ариутгалын бодисын нөөцийг нэмэгдүүлэх, халдваргүйтэл ариутгалын ажлыг тогтмол хийх

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд “Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө” гэж тусдаа бие даасан төлөвлөгөө байхгүй байна. Загварын дагуу боловсруулсан сургууль ч байхгүй

байна. Харин Баянхонгор аймгийн “16” сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд аюулгүй цэгт цугларах нөхцөл байдалд ямар арга хэмжээ авахыг төлөвлөсөн байна.

Хүснэгт 21. Баянхонгор аймгийн “16” сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд аюулгүй цэгт цугларах арга хэмжээг төлөвлөсөн байдал

Алхам	Нөхцөл байдал	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч
8	Гадна цугларах талбайд гарах	“Сургуулийн гадна цугларах талбайд ангиудыг тус тусад нь байрлуулж бүртгэнэ. Гэмтэл бэртэл байгаа эсэхийг шалгана. Хэрвээ хэн нэгэн сурагч гэмтсэн байвал түүнд анхны тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллагад шилжүүлэх”	-	Эрэн хайх нүүлгэн шилжүүлэх баг	Яаралтай тусламжийн баг

Дээрх хүснэгтээс харахад байгууллагын дэргэдэх аюулгүй талбай нь хаана байгаа ямар талбай болох, хаана цугларах, сургуулийн хэмжээний нийт хэдэн сурагчдийг хэр хугацаанд гаргах, хариуцах албан тушаалтан нь тодорхойгүй, “эрэн хайх нүүлгэн шилжүүлэх баг”-т хэн байдаг, хэн хариуцаад гаргах нь тодорхой бус байна.

Гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараах үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг харьцуулан үзэхэд, хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдалгүй зохион байгуулахын тулд гамшгийн өмнө сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, цахим болон зайнаас сургалт явуулах багшлахуйн арга зүйд суралцах, суралцагчдад суралцахуйд сургах арга зүйг эзэмшүүлэх талаар огт тусгагдаагүй байна.

Хүснэгт 22. Гамшгийн өмнө, үед, дараа хэрэгжүүлэх арга хэмжээг харьцуулсан

Чиглэл	Гамшгийн өмнө	Гамшгийн үед	Гамшгийн дараа
Дэд бүтэц	-Түлшний нөөц бэлтгэх, -Барилга байгууламжид гэмтэл учрахаас сэргийлэх, -Цахилгааны үүсвэр тасалдахаас сэргийлэх, -Галын аюулгүй байдлыг сахих, -Өвс тэжээл, хужир шүү нөөцлөх - Нөөц цахилгаан үүсгүүртэй болох	-Түлшний нөөцийг тодотгох, -Цахилгаан доголдохоос сэрг-х -Усан хангамж доголдохоос сэргийлэх -Ариун цэврийн байгууламж доголдохоос сэргийлэх хариу арга хэмжээ авах -Дулаан алдагдлыг тогтмол хэмжих,	-
Боловсролыг дэмжих үйлчилгээ үзүүлэх	- Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах журам, төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах - Хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлж ажиллах	- Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах хэсэгт тодотгол хийх - Цахим болон хэвлэмэл сургалтын хэрэглэгдэхүүнийг гэрийн эргэлтээр болон	-

	бэлэн байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гаргах - Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг шинэчлэх	харилцаа холбооны сувгуудаар хүргэх ажлыг зохион байгуулах - Танхимын болон цахим зайн хосолсон хэлбэрээр зохион байгуулах	
--	---	---	--

Дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх зарим арга хэмжээ нь “салхи шуурганы улмаас барилга байгууламжид гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх”, “цахилгааны эх үүсвэр тасалдахаас сэргийлэх” зэрэг байдлаар туссан нь урьдчилан сэргийлэхийн тулд авах хариу арга хэмжээ нь тодорхойгүй байна. Гамшгийн өмнө “тасалдахаас сэргийлэх”, “гэмтэл учрахаас сэргийлэх” арга хэмжээ авна гэсэн бол гамшгийн дараа ч “доголдохоос сэргийлэх хариу арга хэмжээ авах” зэргээр авах хариу арга хэмжээ нь тодорхойгүй, гамшгийн дараа сэргээн босгох, хэвийн үйл ажиллагаанд оруулахын тулд авах арга хэмжээ нь тусгагдаагүй, хоорондоо уялдаа холбоогүй туссан байна.

Мөн “Гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-нд онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөсөн байдал харагдаж байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд гамшгийн үед авч хэрэгжүүлэх “25-аас дээш хүүхэдтэй анги бүлгийг группээр хичээллүүлэх” арга хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 23. “Гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-нд тусгах арга хэмжээг “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан байдал

ЕБС-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө /сумд кодоор/	Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө
2	Газар хөдлөлтийн аюулын тухай дохиогоор ажиллах аргад багш, ажилтан, сурагчдыг сургаж дадлагажуулах
17	Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байх шаардлагыг хангаж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах
6	- Хичээлийн болон дотуур байрын цахилгаан дулаан усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа доголдох, түлшний нөөцийг тодотгох, хомсдол үүсэхээс сэргийлэх, хариу арга арга хэмжээ авах
8	Барилгын аюулгүй гарц, схем зураглалыг байр, давхар бүрт байрлуулах, нийт багш, ажилчид, сурагчдад таниулах

Хэрэгжүүлэх хугацааг “тухайн үед”, “тухай бүр”, “гамшгийн үед”, “Ч+1 цаг тутам” гэх зэргээр тусгасан байна. Эндээс “тухайн үед”, “тухай бүр” эсвэл огт хугацаа бичээгүй нь нийт төлөвлөгөөний 90.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 24. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хугацааг тусгасан байдал

аймаг	Сумын ГХТ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа
Сүхбаатар	17	Аймгийн төвөөс алслагдсан сумдын хүүхдүүдийн судалгааг нарийвчлан	Тухайн үед

		гаргаж, байршлыг тогтоон, холбоо барих утасны дугаарыг олж, эцэг эх асран хамгаалагчийн талаар үнэн зөв мэдээлэлтэй байх	
	8	Газар хөдлөлтийн аюулын тухай дохиогоор ажиллах аргад ажилтан, албан хаагч, иргэдийг сургах	Улирал бүр
Баянхонгор	2	Сургуулийн түлээ нүүрс, хоол хүнс, аж ахуй малын тэжээл, өвсний нөөцийг бүрдүүлэх, өвлийн бэлтгэлийг хангах	7-10-р сар
	16	Мэргэжлийн байгууллагаас гаргасан үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийн дагуу сургуулийн хэмжээнд аюулгүй байдлаа хангах сургалт, сурталчилгаа зохион байг-х	Жил бүр
Дундговь	12	Сургуулийн хэмжээнд өвлийн бэлтгэлийг хангах, түлээ түлш, хоол хүнсний нөөц бүрдүүлэх	Жил бүр

Төлөвлөгөөний загварт хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэх хугацааг цаг, минут, хоногоор нарийвчлан гаргадаг байна.

“Хариуцах албан тушаалтан”-ыг томилохдоо албан тушаалаар бус овог нэрээр томилгоожуулсан байдал харагдаж байна.

Хүснэгт 25. Хэрэгжүүлэх арга хэмжээг томилгоожуулсан байдал

Аймгийн нэр	Сумын ГХТ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн
Сүхбаатар	17	Байгууллагын хэмжээнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Ц.Ц
	8	Цаг агаарын аюултай үзэгдлийн талаар зарлан мэдээлэл байнга дамжуулж байх	Гамшгаас хамгаалах аврах бүрэлдэхүүн
Баянхонгор	2	Гамшгийн үед ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнийг халуун хоол, цай хүнсээр хангах	Нярав Я.Ц
	16	Газар хөдлөлтийн чичирхийллийн эхний шинж тэмдгээр суу, нуугд, хүлээ дохиог өгнө	Багш ажилчид
Дундговь	12	Сурагчдыг гэр бүлд нь хүлээлгэн өгөх	-
	13	Хүн малын гоц халдварт өвчний талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	ЭМТ Н.Б

Хариуцах албан тушаалтныг хэрхэн тусгасанд шинжилгээ хийхэд хүний нэрээр “Дотуур байр болон хамаатан садангийндаа амьдарч буй сурагчдын судалгаа бүртгэлийг гаргах, эцэг эх асран хамгаалагчтай холбогдох хаяг, утасны дугаар, арга хэлбэрийг тодруулах” арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч нь сургалт аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтнууд, зудын гамшгийн үед “Дотуур байрны сурагчдын аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын арга хэмжээ авах” арга

хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч нь “хүүхэд хамгааллын баг”⁶, химийн бодис алдагдах үед “хими биологийн багш нар” гэх байдлаар тусгасан байна.

Эндээс үзэхэд хүүхэд хамгааллын ямар арга хэмжээг авах нь тодорхойгүйгээс гадна “хүүхэд хамгааллын баг”, “аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан”, “холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан”, “харуул хамгаалалтын баг” зэргээр нэрлэсэн нь шаардлагатай тохиолдолд хэн хариуцан хэрэгжүүлэх нь тодорхой бус байна. Иймээс хариуцан хэрэгжүүлэгч нь боловсролын байгууллага дахь албан тушаалаар захирал, сургалтын менежер, хими биологийн багш нар гэх мэтээр томилгоожуулах нь үр дүнтэй байх юм.

Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг зудын эрсдэлийн мэдээтэй харьцуулж үзэхдээ, Ерөнхий боловсролын сургуулиудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн төрөл тус бүрээр боловсруулсан байдлыг шинжилсэн ба гамшгийн төрлөөр гамшгийн өмнө, үед, дараа гэсэн 3 хүрээнд бүрэн боловсруулсныг (≡), 2 хүрээнд боловсруулсныг (=), зөвхөн нэг хүрээнд боловсруулсныг (-), 3 хүрээнд огт боловсруулаагүйг (0) тэмдгээр тэмдэглэгээ хийв.

Хүснэгт 26. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн төрөл тус бүрээр боловсруулсан байдал

Аймаг	Сум	Төлөвлөгөө боловсруулсан он	Гал түймэр	Газар хөдлөлт	Зуд гамшиг	Хүчтэй салхи шуурга	Халдварт өвчин	Аюултай бодис материал алдагдах	Галт халдлага хүчирхийлэл	Техник технологийн холбогдолтой осол
Баянхонгор	1	2021	0	0	0	0	≡	0	0	0
	2	2023	=	=	=	=	=	-	0	0
	16	2023	≡	≡	≡	≡	≡	≡	≡	0
Сүхбаатар	17	2023	=	=	=	-	=	=	0	0
	8	-	≡	≡	≡	0	≡	=	0	≡
	6	2024	0	0	≡	0	0	0	0	0
	9	-	0	0	=	0	0	0	0	0
	10	-	0	0	≡	0	0	0	0	0
Дундговь	12	2013	≡	≡	≡	-	≡	≡	≡	0
	13	-	≡	≡	≡	≡	≡	≡	0	0
	14	2022	≡	=	0	0	≡	0	≡	0

⁶ Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЕБС-ийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, 2023, 23 дугаар тал

Ерөнхий боловсролын 11 сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнөөс Баянхонгор аймгийн “2” сум 2023 оны 1 дүгээр сарын 09-нд тодотгол хийгээд, 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр төлөвлөгөөгөө баталсан. Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 2013 оны 9 сард төлөвлөгөө баталж, 2016 оны 3 сард тус тус тодотгол хийсэн байна. Харин үлдсэн 9 сумын ерөнхий боловсролын сургууль тодотгол хийгээгүй байна. Тодотгол хийх болсон шалтгаан, утгыг төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Баянхонгор аймгийн “1”, “2”, “16” сумдын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөн дэх зудын гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тус аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны мэдээтэй харьцуулж үзэхэд Баянхонгор аймгийн 2023 оны зудын эрсдэлийн мэдээгээр “1” сум их болон нэн их эрсдэлтэй, “2”, “16” сумдын нутаг зудын их эрсдэлтэй гэж гарсан байна⁷. Гэтэл “1” сумын сургуулийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд зудын өмнө, үед, дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээг огт тусгаагүй, “2”, “16” хоёр сумын төлөвлөгөөнд зудын эрсдэлт нөхцөл байдал үүсэхээс өмнө “Өвлийн бэлтгэлийг хангах”, “Түлээ түлш, хоол хүнсний нөөц бүрдүүлэх”, “Дотуур байр болон хамаатныдаа байгаа сурагчдын бүртгэл судалгаа гаргах”, “Үүссэн нөхцөл байдлын талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан мэдээллийн дагуу сургалт сурталчилгаа зохион байгуулах” арга хэмжээнүүдийг тусгасан нь адил байна. Харин зудын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд “16” сумын төлөвлөгөөнд дэд бүтцийн болон сурагчдыг эцэг эх асран хамгаалагчгүй замд, хээр хөдөө явуулахгүй байх”, “нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх зорилгоор бусад байгууллагуудтай холбоотой ажиллах”, “эцэг эхтэй холбоотой ажиллах”, “дотуур байранд нэмэлт эргүүл жижүүр ажиллуулах”, “гэр бүлийнх нь талаар үнэн зөв мэдээлэл сурагчдад өгөх” зэрэг арга хэмжээг төлөвлөн, хичээл сургалттай холбоотой арга хэмжээг огт төлөвлөөгүй байна. “2” сумын хувьд “албан хаагчдад аюулын тухай зарлан мэдээлэх”, “дохио хүлээн авмагц албаны даргад мэдэгдэх” арга хэмжээг төлөвлөснөөс харахад төлөвлөгөөнд тодотгол хийх үйл явц нь цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, зудын эрсдэлийн мэдээтэй огт холбоогүй байна гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөө боловсруулсны дараа тодотгол хийснээр төлөвлөсөн арга хэмжээнд ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 27. Зудын эрсдэлийн тойм мэдээ

Аймгийн нэр	Он	Зудын нэн их эрсдэлтэй	Их эрсдэлтэй	Эх сурвалж
Баянхонгор	2020 оны 12 сар	85 гаруй хувь	15 орчим хувь	http://bayankhongor.tsag-agaar.gov.mn/
	2023 оны 11 сар	90 гаруй хувь	10 хувь	http://bayankhongor.tsag-agaar.gov.mn/
Дундговь	2023 оны 11 сар	9 хувь	39 хувь	Дундговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв

⁷ <http://bayankhongor.tsag-agaar.gov.mn/uploads/zud.2023.jpg>

	2024 оны 1 сар	75 хувь		https://www.unuudur.mn/a/264026
Сүхбаатар	2021 оны 1 сар	40 орчим хувь	60 орчим хувь	Сүхбаатар аймгийн зудын эрсдэлийн мэдээ
	2023 оны 2 сар	35.9 хувь	53.7 хувь	Сүхбаатар аймгийн зудын эрсдэлийн мэдээ
	2024 оны 1 сар	69.2 хувь	30.8 хувь	Сүхбаатар аймгийн зудын эрсдэлийн тойм

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор, Сүхбаатар, Дундговь аймгийн хувьд нэн их болон их эрсдэлийн давтамж жил ирэх тусам өндөр болж байгаа дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл, энэ жилийн зудын нөхцөл байдал анх удаа болж байгаа бус өмнө онуудад мөн эрсдэлт нөхцөл байдал болж байсан байна. Төлөвлөгөө боловсруулсан оныг харахад 2021 оноос эхлэн боловсруулж эхэлсэн дүр зураг харагдаж байна. Эрсдэлт нөхцөл байдал жил ирэх тусам давтагдаж байгаатай холбоотой гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж эхэлсэн нь ажиглагдаж байна.

ГУРАВ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕИЙН СУРГАЛТЫН ОРЧНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд: эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж эрхийг тусгаж өгчээ.


Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд суралцагчийн эрх, үүргийн 10.1.1 эрүүл, аюулгүй, жөндөрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлөөс суралцах эрхтэй гэсэн бол ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 – стандартын зорилгод “Ерөнхий Боловсролын Сургуулийн гадаад болон дотоод орчинд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, аюулгүй байдлыг хангахад оршино” гэж тус тус тодорхойлсон байна.

Иймээс бидний судалгаанд хамрагдсан сургууль дотуур байр нь аюулт үзэгдлийн үед хүүхдийн эрүүл аюулгүй байдал хангасан орчин, нөхцөлд суралцах эрх болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бэлэн байгаа эсэхийг тодруулахыг зорьлоо.

3.1. Дотуур байрны барилга байгууламж


Судалгаанд нийт 45 сургууль болон дотуур байрны орчинг хамрууллаа.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан сургууль ба дотуур байрны ашиглалтад орсон он, хувиар



Судалгаанд хамрагдсан сургууль ба дотуур байрны ашиглалтад орсон оныг авч үзэхэд 51.1 хувь нь 1975-1989 онд ашиглалтад орсон ба 1944, 1962 онд ашиглалтад орсон барилга 4.4 хувь байна. Ашиглалтад ороод 51.1 хувь нь 8-15 жил болж байгаа сургууль, дотуур байр байгаа бол 15.6 хувь нь 2017-2024 онд ашиглалтад орсон барилга байна. Нийт дотуур байрны барилга насжилт өндөр барилга байгаа нь эрсдэлтэй байна.

Зураг 2. Акталсан болон актлаагүй барилга, хувиар



Хүүхүүд амьдарч байгаа дотуур байрны 24.3 хувь нь акталсан барилга, 26.7 хувь нь актлаагүй ч насжилт өндөртэй барилга байна.

Ийм барилга бүхий дотуур байранд өвлийн хүйтэн цаашилбал зудын хүнд нөхцөл байдалд амьдрахад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэх нь дамжиггүй юм. Нийт сургуулийн дотуур байранд үүсээд байгаа суудал нь цонхноос дулаан алдах, пар халахгүй байх, пар хагарах, усны шугам хөлдөх, түлээ түлшгүй болох, мөөгөнцөртөх, дээврээс ус гоожих, тохитой бие засах, ариун цэврийн өрөөгүй байх, нэг өрөөнд олуулаа амьдрах зэрэг нэлээд хүндрэлтэй асуудлууд тулгарах нь зүй ёсны юм.

Дотуур байр нь 1950-иад онд ашиглалтад орсон байранд хүүхдүүд амьдарч байна. Шуурга боллоо гэхэд дээвэр нь ойчоод, нурвал яах вэ, аль хэдийн ашиглах боломжгүй болсон байранд хүүхдүүд эсгий гуталтай, гадуур хувцастайгаа сууж хичээл хийж байгаа харагддаг. Хүйтэн ангид хичээл хийж байгаа хүүхэд ямар хичээлээ ойлгох юм. Нэгдсэн халаалт байсан бол байгууллагууд тус тусдаа өөрөө халаалтаа шийдэж байна.

Сумын засаг даргын ярилцлагаас

“Дотуур байр маш хүйтэн. 1-р давхрын 5 тасаг байсныг дээд давхарт нь бүх хүүхдийг нь нэмж оруулсан. Шинэ барилга барих гэж суурийг нь тавьсан барилгыг зогсоосон. Цэвдэгтэй учир далий буруу баригдсан. 1985 онд барьсан хуучин байр, дулаан алдалт ихтэй. Хүнд байдал үүссэн”.

Сургуулийн захиралтай хийсэн ярилцлагаас

3.2. Гадаад орчин

ЕБС-ийн орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага стандарт (MNS 6782;2019)-ын 4.3 – т Сургуулийн гадаад орчин – “Суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалах нөхцөлийг бүрдүүлж, стандартын дагуу байгуулсан тоглоом, биеийн тамир, туршилтын болон

задгай талбай, ногоон байгууламж, аж ахуйн үйл ажиллагааны бүс бүхий орчин” гэж тодорхойлсон байна.

ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлагын нэр томьёо, тодорхойлолтод сургуулийн дотоод орчин нь – Олон нийт, иргэний барилгын норм дүрэм, стандартын дагуу барьсан сургуулийн барилга байгууламжийн дотор суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах тэгш боломжийг бүрдүүлсэн материаллаг орчин гэж 4.5-д тодорхойлжээ. Энэ шаардлагыг хангасан эсэх талаар авч үзлээ. Тус стандартын сургуулийн гадаад орчинд тавих аюулгүй байдлын шаардлагын 5.1-д эзэмшил газар, 5.1.4-д сургуулийн эзэмшил газар нь эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих, буулгах боломжтой байна ...гэж тусгасан байна.

Хүснэгт 28. Сургууль, дотуур байр нь эмнэлэг, онцгой байдлын, том оврын машин орж гарах гарцтай эсэх

Үзүүлэлтүүд	хувь
Эмнэлэг, гал команд, тусгай зориулалтын тээврийн хэрэгслэл нэвтрэх боломжтой	20.0
1-3 машин	46.67
4-6 машин	8.89
7-10 машин	26.67

Сургууль, дотуур байрны 20.0 хувь нь тусгай зориулалтын тээврийн хэрэгслэл нэвтрэх боломжтой ба 46.8 хувь нь 1-3 машин багтах зайтай, 26.8 хувь нь 7-10 машин багтах зайтай байгаагаас харахад сургууль, дотуур байр нь аюул тохиолдсон үед тээврийн хэрэгслэл багтах боломжтой буюу сургуулийн гадаад орчинд тавих аюулгүй байдлын шаардлагын 5.1-д эзэмшил газар 5.1.4 -д сургуулийн эзэмшил газар нь эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих, буулгах боломжтой байна гэсэн заалт хэрэгжих боломжтой байна.

Сургууль, дотуур байр нь гэнэтийн аюул тохиолдсон үед гал унтраах багаж төхөөрөмжөөс гадна барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй баригдсан байх стандарт шаардлагууд байдаг байна. Судалгаанд хамрагдсан сургууль, дотуур байрны гадна болон дотоод орчны ажиглалтаар гамшгийн үед гарын дор хэрэг болох багажтай эсэхийг тодруулан авч үзлээ.

Хүснэгт 29. ... аймгийн сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний багаж хэрэгслийн тооцоо, жишээгээр

Гамшгийн төрөл	Объект йн гал түймэр	Хүчтэй цасан болон шороон шуурга	Газар хөдлөл т	Хүний гоц халдва рт өвчин	Үер ус	Техникийн осол

Хүн хүч	Удирдлага						
	Орон тооны бус штаб						
	Ажиллах хүний тоо						
Багаж хэрэгсэл	Хүрз						
	Малтуур						
	Галын дэгээ						
	Элс	мЗ		мЗ			
	Эсгий / 2х2 /	ш		ш			
	Дотуур крант						
	Хөрөө						
	Сүх						
	Лоом						
	Гагнуурын аппарат						
	Сантехникийн багаж	ком		ком			ком
	Цахилгааны багж	ком		ком			ком
Анхны тусламжийн бүлэг	Халуун хэмжигч				ш		
	Ариутгал цэвэрлэгээний бодис				төрөл		
	Наалт хөвөн, бинт зэрэг ороох, боох материалаас эхлээд өвчин намдаах эм бэлдмэл бүхий иж бүрдэл цүнх						

Жич: Өөр өнгөөр тэмдэглэгдсэн нь тухайн гамшгийн үед ашиглагдах ба хүн хүчний хувьд заавал нэр цохон тэмдэглэх шаардлагатай байгааг илэрхийлнэ.

... аймгийн сургуулийн төлөвлөгөөнд байгаа багаж хэрэгслэлийн тооцооноос ямар гамшгийн үед ямар багаж хэрэг болдог болон сургуулийн хүн хүчний тоо, багаж хэрэгслийн тоо, анхны тусламжийн үед хэрэглэх эм болон бусад хэрэгслийн тоог

тусгасан байдаг нь нэг талаас аюулгүй ажиллагааг хангах, шаардлагатай үед бэлэн байдлыг хангах боломж олгодог байна.

Сургуулийн жилийн төсвийн 1 хувьтай тэнцэх мөнгө төсөвт хувиарлагдан ирж онцгой байдлын үед ашиглах заалт байдаг ч би 10 жил сургуулийн захирал хийхэд нэгч удаа төсөвт мөнгө орж ирж байгаагүй бид нар бусад эх үүсвэрээс гал унтраагуур МРЯ-4 ч юм уу бусад хэрэгслэл авч ажиллагааг хангаж байдаг.

Сургуулийн захирлын ярианаас

Аюулт үзэгдлээс шалтгаалан сургууль, дотуур байр нь тухайн үед зайлшгүй хэрэглэгдэх багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж байх шаардлагатай байдаг байна. Энэ нь тухайн үед шаардлага гарвал гарын дор хэрэглэгдэх боломжтой байх ба ажиллах хугацаа ажиллагаатай эсэхийг тогтмол шалгаж байх шаардлагатай байдаг байна. Аюулт үзэгдлийг дотор нь хэд хэдэн гамшгийн төрлөөр ангилдаг байна. Үүнд: Гал түймэр, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, хүний гоц халдварт өвчин, үер, усны аюул, техникийн осол гэх мэт.

Аюулт үзэгдлийн үеийн багаж хэрэгсэл

Объектод гал гарсан үед элс, хүрз малтуур, галын дэгээ, эсгий, дотуур крант, хөрөө сүх, лоом, цахилгааны багаж ашигладаг байна.

Хүснэгт 30. Аюул тохиолдсон үед хэрэглэж болох багаж, хувиар

Сургууль	Хүрзны тоо		Малтуурын тоо			Галын дэгээний тоо		
	байхгүй	1-5 ширхэг	байхгүй	1 ширхэг	2-3 ширхэг	байхгүй	1 ширхэг	2-3 ширхэг
Аймгийн		66.6		66.7	33.3		66.7	33.3
Сумын	45.5	50.5	72.7	22.7	4.5	63.6	31.8	4.5
Аймгийн дотуур байр	33.3	66.6	33.3	33.3	33.3	66.7	33.3	
Сумын дотуур байр	41.2	58.8	64.7	29.4	5.9	82.4	17.6	
нийт	40.0	55.6	62.2	28.9	8.9	66.7	28.9	4.4

Дээрх хүснэгтээс харахад сургууль дотуур байр нь аюул тохиолдсон үед хүн бүрд хүрэлцээтэй хангалттай багаж хэрэгсэлгүй байна.

Хүснэгт 31. Галын аюулын үеийн хэрэгслэл гал унтраах МРЯ-4 ажиллагаатай эсэх, тоо ширхэг

Сургууль	МРЯ-4 ажиллахгүй	байхгүй	1-3 ширхэг	4-5 ширхэг	10-13 ширхэг	22-27 ширхэг
Аймгийн				33.3	66.7	
Сумын	9.1	27.3	27.3	18.2	0.0	18.2
Аймгийн дотуур байр			33.3		66.7	
Сумын дотуур байр	35.3	11.8	23.5	23.5	5.9	

нийт	17.8	17.8	24.4	20.0	11.1	8.9
------	------	------	------	------	------	-----

Галын аюулын үед өргөн хэрэглэгддэг МРЯ-4 гал унтраах хэрэгслэл нь аймгийн төвийн сургуулиудад 10-13 ширхэг байдаг бол харин сумын сургуулиудад хангалтгүй 1-5 орчим ширхэг байна. Мөн сумын сургууль, дотуур байрны 17.8 хувь нь гал унтраах хэрэгсэлийн хугацаа дууссан үзмэр хэлбэрээр байршуулсан байна.

Хүснэгт 32. Аюултай үед ашиглах элс ба эсгийний тоо, хувиар

Сургууль	Элсний тоо				Эсгийний тоо		
	байхгүй	1-2 ширхэг	4-5 ширхэг	22 ширхэг	байхгүй	Стандарт хангаагүй	1-2 ширхэг
Аймгийн	33.3	33.3	0.0	33.3	33.3	33.3	33.3
Сумын	45.5	50.0	4.5	0.0	81.8	9.1	9.1
Аймгийн дотуур байр	0.0	66.7	33.3	0.0	66.7	33.3	0.0
Сумын дотуур байр	52.9	47.1	0.0	0.0	82.4	11.8	5.9
нийт	44.4	48.9	4.4	2.2	77.8	13.3	8.9

Сумын сургууль, дотуур байрны 82.4 хувь нь эсгий байхгүй буюу байсан ч стандарт шаардлага хангахгүй сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлж байна. Эсгий 2х2 м² хэмжээтэй байх нь стандарт хэмжээг илэрхийлдэг байна.

Хүснэгт 33. Онцгой байдлын үед ашиглагдах хөрөө, сүх, лоомны тоо, хувиар

Сургууль	Хөрөө			Сүх		Лоом		
	байхгүй	1 ширхэг	2 ширхэг	байхгүй	1 ширхэг	байхгүй	1 ширхэг	2 ширхэг
Аймгийн		100			100		66.7	33.3
Сумын	68.2	27.3	4.5	77.3	22.7	54.5	40.9	4.5
Аймгийн дотуур байр	33.3	66.7		33.3	66.7	33.3	66.7	
Сумын дотуур байр	76.5	23.5		88.2	11.8	64.7	35.3	
нийт	64.4	33.3	2.2	73.3	26.7	53.3	42.2	4.4

Онцгой байдлын үед тухайлбал, объектийн гал түймэр, газар хөдлөлтийн үед хөрөө, сүх, лоомыг хэрэглэдэг. Дээрх хүснэгтээс харахад сумын сургуулийн дотуур байр нь аюултай үзэгдлийн үед хэрэглэх багажгүй байгаа нь түүгээр хангах шаардлагатайг илэрхийлж байна.

Хүснэгт 34. Аюул ослын үед хэрэглэгдэх гагнуур, сантехник, цахилгааны багаж

Сургууль	Гагнуурын аппаратын тоо		Сантехникийн багц багаж		Цахилгааны багаж	
	байхгүй	1 ширхэг	байхгүй	1 ширхэг	байхгүй	1 ширхэг
Аймгийн		100	33.3	66.7	33.3	66.7
Сумын	54.5	45.5	59.1	40.9	72.7	27.3

Аймгийн дотуур байр	66.7	33.3	66.7	33.3	66.7	33.3
Сумын дотуур байр	82.4	17.6	58.8	41.2	70.6	29.4
Нийт	62.2	37.8	57.8	42.2	68.9	31.1

Сургууль, дотуур байр нь гагнуурын аппарат, сантехникийн багц багаж, цахилгааны багажтай байх шаардлагатай бөгөөд аймгийн төвийн сургууль багц багажтай, сумын сургууль нь 45.5 хувь нь гагнуурын, 40.9 хувь нь сантехникийн, 27.3 хувь нь цахилгааны багажтай байна. Аймгийн төвийн дотуур байрны хувьд 33.3 хувь нь гагнуурын, 33.3 хувь нь сантехникийн, 33.3 хувь нь цахилгааны багажтай байгаа нь хангалтгүй гэж үзэж болохоор байна. Мөн сумын дотуур байрны хувь ч багаж хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

3.3. Анхны тусламжийн багц

Анхны тусламжийн цүнхэнд байх хөвөн наалт, өвчин намдаах эм, бинт, ороох материал, халууны шил, ханиадны эм, зайнаас халуун хэмжигч гэх мэт хэрэгслэл зайлшгүй байдаг байна.

ЕБС -ийн орчны орчны аюулгүй байдал MNS 6782:2019 стандартын 6.15-д эмчийн өрөө буюу 6.15.3-д эмчийн өрөөг яаралтай тусламжийн эм хэрэгсэл, эмийн цоожтой шүүгээ яаралтай тусламжийн багцаар хангана гэж заасан байна. Үүний дагуу судалгаанд хамрагдсан сургууль, дотуур байрны хувьд анхан шатны тусламжийн цүнхний тоо болон дортор нь зайлшгүй байх хэрэгслийг авч үзлээ. Үүнд: аймгийн төвийн сургуулиудын хувьд 66.7 хувь нь 1-15 ширхэг багц цүнхтэй байгаа бол сумын сургуулийн 59.1 хувь нь 1-15 ширхэг цүнхтэй, аймгийн төвийн дотуур байрны 66.7 хувь нь 1-5 багц цүнхтэй, сумын дотуур байр нь 64.7 хувь нь 1-15 цүнхтэй байна.

Бидний судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд анхны тусламжийн цүнхэнд бинт, ороох материал, аймгийн төвийн сургуулийн хувьд бүрэн байгаа бол наалт, хөвөн, өвчин намдаах эм, ханиадны эм 33.3 хувьд байна. Сумын сургуулийн хувьд ханиадны эм, өвчин намдаах эм 31.6 хувь нь байгаа бол наалт, хөвөн 26.3 хувь нь, халууны шил 63.2 хувь нь байгаа нь багцаар байна гэж үзэх нь хангалтгүй байгааг илэрхийлж байна. Аймгийн төвийн болон сумын дотуур байрны хувьд ч энэ үзүүлэлт маш бага хувьтай байгаа нь аюул тохиолдсон үед хэрэглэх боломжгүй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 35. Сургууль, дотуур байрны дотоод орчны аюулгүй байдал буюу орц, гарц

Үзүүлэлтүүд	Аймгийн сургууль	Сумын сургууль	Аймгийн дотуур байр	Сумын дотуур байр	Нийт
Хаалга түлхэж онгойно	100	100	100	88.2	95.6
Гарц чөлөөтэй	100	86.4	66.7	70.6	80.0
Хаалга хаагдаад шууд цоожлогдохгүй	100	90.9	66.7	82.4	86.7
Урсгал хөдөлгөөн харуулсан схем	66.7	77.3	66.7	58.8	68.9
Гарцын тэмдэглэгээ гэрэлтдэг		45.5	33.3	29.4	35.6

Сургууль, дотуур байрны хаалганы онгойх, хаагдах, гарц чөлөөтэй эсэх аюул тохиолдсон үед барилгаас гарах урсгал хөдөлгөөнийг чиглэлийг харуулсан зураг схемтэй эсэх, гарцын тэмдэглэгээ нь харанхуйд гэрэлтдэг байх шаардлага тавигддаг байна.

Бидний судалгаанд хамрагдсан сургууль, дотуур байрны хувьд хаалга түлхэж онгойдог урсгалтай аймгийн төвийн сургуулийн гарц чөлөөтэй, гарцын тэмдэглэгээ харанхуйд гэрэлтдэг байна.

Сургууль болон дотуур байр нь тэргэнцэрийн зориулалтын замтай байх стандарт шаардлага байдаг бөгөөд аймгийн төвийн сургуулийн 33.3 хувь нь, сумын сургуулийн 40.9 хувь нь, сумын сургуулийн дотуур байрны 24.4 хувь нь тэргэнцрийн зориулалтын замтай байна.

Аймгийн төвийн сургууль нь аюулгүй байдлын дохиололын систем, агааржуулалтын систем, галын утаа мэдрэгч байхгүй байгаа ба сумын сургуулийн хувьд агааржуулагч, галын утаа мэдрэгч 40.9 хувьд нь байгаа бол аюултай үед 31.8 хувьд нь дохио дуугарах боломжтой байна. Сумын дотуур байрны хувьд 17.6 хувь нь дохиоллын системтэй, 23.5 хувь нь агааржуулалтын болон утаа мэдрэгчтэй байгаа нь нийт сургууль, дотуур байрны хувьд хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 36. Газар хөдлөлт болон аяга зайлуулагч, салхины хүчийг тэсвэрлэх чадвар

Сургууль	Газар хөдлөлтийн ямар хэмжээнд тэсвэртэй эсэх		Аянга зайлуулагчтай эсэх	Дээвэр, гадна хана, агаар чийгний нөлөөнөөс хамгаалагдсан, салхины хүчийг тэсвэрлэх чадвартай эсэх		
	1-5 балл	6-8 балл		Тийм	Үгүй	Мэдэхгүй
Аймгийн	33.3	33.3	66.7	66.7		33.3
Сумын	27.3	27.3	45.5	68.2	4.5	27.3
Аймгийн дотуур байр	33.3			66.7		33.3
Сумын дотуур байр	29.4	17.6	47.1	64.7	11.8	23.5
Нийт	28.9	22.2	44.4	66.7	6.7	26.7

ЕБС-ийн орчны аюулгүй байдал барилгын стандартын 5.2.3-д Барилга байгууламжийн ашиглалтын явцад газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон барилгад бэхэлгээ, хүчитгэл хийнэ гэж заасан байна. Ийм учир бид газар хөдлөлтийн тэсвэрийн үзүүлэлтийг авч үзлээ. Сургууль болон дотуур байрны барилгын зураг бүрд газар хөдлөлийн ямар хэмжээнд тэсвэртэй талаар бичигдсэн байдаг ба аймгийн төвийн сургуулийн 33.3 хувь нь 6-8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй, сумын сургуулийн 27.3 хувь нь, сумын дотуур байрны 17.6 хувь нь 6-8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй байна. Сургууль болон дотуур байр нь барилгын стандартын 5.2.2 сургуулийн барилга байгууламж нь цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх

бөгөөд аянга зайлуулагч газардуулагчтай байна гэж заасан.Тухайлбал, бидний судалгаанд хамрагдсан сургууль, дотуур байрны хувьд аймгийн төвийн сургуулийн 66.7 хувь, сумын сургуулийн 45.5 хувь, сумын дотуур байрны 47.1 хувь нь аянга газардуулагчтай байна.

Дотуур байр нь ашиглалтад орсон он, хэр зэрэг чанартай баригдсан зэргээс шалтгаалан онцгой нөхцөл байдал, зудын үед үүссэн бэрхшээлүүдийг багш нар доорх байдлаар нэрлэсэн байна. Үүнд:

- Ундны усны хомсдолд орсон. Халуун, хүйтэн ус цэвэршүүлдэг хөлдөөд ажиллахгүй байсан.
- Ус сургуулиас зөөж байсан учир хүндрэлтэй байсан.
- Хүүхдүүд усанд орж чадахгүй байх, дотуур хувцасаа угааж чадахгүй байх гэх мэт бэрхшээлүүд байсан.
- Эмийн хүрэлцээ бага, санхүүжилтгүй.
- Тог тасрах, тогны хязгаарлалт хийж байсан
- Цонхоор дулаан алдаад маш их хүйтэн
- 2 тасаг хүүхэд авах боломжгүй болсон
- Цонхны хөшиг сөхөхгүй үргэлж хаалттай
- Дээврээс ус гоождог. Их чийгтвэл мөөгөнцөртөх тохиолдол их байсан. Дулаан алдалт л маш их байсан.
- Дулаан бага зэрэг доголдсон сургууль нүүрсээ татаж авч амжаагүй тэр үед бензин хомс байсатай холбоотой
- Паар задарсан.
- Номын сан, хүүхэд хөгжил, компьютерын өрөө, хүмүүсийн суудаг өрөө маш хүйтэн байсан.
- 4 давхарт цонх нь цанатаад мөөгөнцөртөх асуудал үүссэн байгаа. Энэ бол зуд болоод байгаа биш барилгын чанартай холбоотой байсан
 - Ид өвлийн үед маш сэрүүхэн байдаг
 - Мах л нөөцлөөгүй болохоор сайн чанартай мах олдоц ховор болоод байсан
- Хүнсний хоолны нарийн ногоонууд таталтгүй болж тасрах байдал гарсан гэж дотуур байрны багш нар дурьдсан байна.

...Нэгдсэн халаалтанд орсон. Өвөл доороо хүүхэд байх боломжгүй. Дээрээ хоолны заал, насан турш гээд 3 өрөө байдаг, тэр өрөөнд хүүхдүүдээ эр, эмээр нь хувааж дааруулахгүйн тулд байлгасан дулаан алдалт маш ихтэй, халаалт муу өгдөг...

..... аймгийн сумын дотуур байрны багшийн ярианаас

Энэ тохиолдолуудад хүүхдүүдээ дааруулахгүй тулд авсан арга хэмжээ:

- Давхар хөнжил тараах
- Цонхоор дулаан алдалтыг скочоор битүүлсэн ч маш их хүйтэн

- Паараа солиулж, дулаан алдалтыг зогсоосон
- Тог тасраад, газар хоол ундаа хийгээд тасалдах юмгүй зохицуулаад ажилласан
- Өмнө нь дээврээсээ, цонхноосоо дулаан алдалт байсныг намар засварласан. Сантехникийг бас янзалсан нь зудыг давахад нөлөөлсөн зэрэг байна.

1978 онд баригдсан. 1 удаа ч их засвар хийгээгүй. Дулаахан газар луу хүүхдээ оруулаад хаах маягаар өвөлжүүлдэг, даардаг, өөрөөсөө галлагаатай үед хэцүү байсан. Одоо төвийн халаалтад ороод сайхан байна. Их засварт орох мөнгө маш багаар оногдсон. Манай дотуур байр нь хамгийн хүйтэн газар өндөрлөг газарт байралсан учир даарах хөөрөх юм гарна. Асуудал зөндөө байгаа...

Сумын дотуур байрны багшийн ярианаас

Цаг агаарын эрс тэс байдал ба хүйтрэл дотуур байрны хэвийн үйл ажиллагаанд нөлөөлсөн эсэхийг тодруулахад ихэнх хүүхдүүд ханиад томуу, томуу төст өвчин тусдаг, даарснаас болж 1 хүүхэд ханиад хүрэхэд 10-20 хүүхдэд халдах байдал ажиглагдсанаас гадна гал тогооныхон аарц, аньс, чацаргана өгч дархлааг нь дэмжиж байсан тохиолдол цөөнгүй байжээ.

Гадаа 00-той дотуур байрны хүүхдүүдэд хүндрэлтэй байсан учир дотор 00-той болох асуудлыг тавьж 00 дотроо хийгээд шийдэж, холболт хийж байгаа, хэцүү байгаа болгоноо хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйн тулд ажиллаж байсан сургууль байв.

Сургуулийн удирдлага дотооддоо зохицуулалтыг хийх ажил голлосон нь судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд нийтлэг байв.

ДҮГНЭЛТ

- Онцгой нөхцөл байдал ялангуяа зудын нөхцөл байдлын үед малчин өрхийн амьдралын нөхцөл байдал нь нүүдлийн шинжтэй байдлыг харгалзан үзэж орон нутагт хамран сургах тойргийг хэрхэн суралцагч болон өрхөд ээлтэй байх талаар бодолцон бодлого үйл ажиллагаандаа уян хатан байх талаар тусгах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй байна.
- Мөн орон нутагт цаг үеийн шинжтэй нөхцөл байдал малчин өрхийн амьдралын хэв маягийг харгалзан урт хугацааны улирлын амралтад зохицуулалтад анхаарал хандуулах нь чухал байна.
- Хичээлдээ ирээгүй сурагчдын хамрагдаж буй боловсролын түвшин, хүйсийн хувьд аваад үзэхэд, дунд ангийн эрэгтэй хүүхдүүд байна. Энэ байдал нь цөөнгүй тохиолдолд сургуулиас завсардах шалтгаан болох магадлалтай байна.
- Олон хоног хичээлдээ ирээгүй сурагчид буцаж сургуульдаа ирэхэд сурагчдын хичээлд анхаарах нь буурах, ар гэртээ санаа зовох байдлаас улбаалан хичээлийн агуулгаас хоцорч байна.
- Гамшиг аюулт үзэгдлийн үед суралцаж буй сурагчдын эрүүл аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөтэй байх шаардлагатай байна.
- Онцгой нөхцөл байдлын үед сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах сургалтын төлөвлөгөө сургуулиудад байна. Ийнхүү төлөвлөхдөө орон нутгийн БГ-аас өгсөн чиглэлийн дагуу судлагдахууны багш нар боловсруулдаг дүр зураг харагдлаа. Харин орон нутгийн Онцгой байдлын Газар, Ус цаг уурын шинжилгээний газар гэх мэт талуудтай хамтардаггүй байна.
- Төлөвлөлтөд багш нарын хамтын ажиллагааны талаар тодорхой хэмжээнд тусдаг. Цаашид хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд сургууль эцэг эх, сурагчдын хамтын үйл ажиллагааны талаар тусгах нь зүйтэй байна.
- Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд танхимын болон цахим сургалтын арга зүйг ерөнхий байдлаар тусгадаг тул арга зүйн хэрэгжилтийн чанар хангалтгүй байхаар дүр зураг харагдлаа. Энд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь техник тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал, цахим орчны бүрдэлт болохыг багш нарын асуулга, нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас харагдаж байна.
- Хичээлийн төлөвлөлт арга зүйдээ боловсролын тусгай хэрэгцээтэй, нийгмийн эмзэг бүлгийн сурагчдыг тусгайлан сургах арга зүйг нарийвчлан тусгах талаар дэмжлэг сургуулиудад шаардлагатай байна.
- Хичээлдээ ирэхгүй байгаа сурагчдад хичээлийн агуулгын хоцрогдлоос урьдчилан сэргийлэхийн тулд сургуулийн зүгээс цахим хичээл, цаасан хэрэглэгдэхүүнийг илгээж байсан байна. Ялангуяа, сургалтын цаасан хэрэглэгдэхүүнийг хүргэж байсныг асуулгад оролцогч багш нарын 73 хувь нь хариулжээ.
- Багш нарын зүгээс хичээлдээ ирэх боломжгүй сурагчдад мөн ирснийх нь дараа хичээлээ хэрхэн нөхөх талаар зөвлөгөөг тогтмол тэгш хүртээмжтэй өгч ажиллах тал дээр сайжруулах хэрэгцээтэй байна. Энэ нь хичээлийн агуулгын хоцрогдлыг

бууруулахаас гадна сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг болох юм. Тэрчлэн хичээлдээ ирсний дараа нэмэлт давтлага өгч ажиллах тал дээр сургуулийн зүгээс албан ёсны зохицуулалтыг бий болгох хэрэгтэй байна.

- Зудын үеийн нөхцөл байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагааны талаар сурагч болон эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийж хэвших шаардлагатай байна.
- Зудын үеийн нөхцөл байдлын үед сургуулиудад тулгамдаж байсан бэрхшээлүүд: эцэг эхчүүдийн хүүхдийнхээ суралцахуйг дэмжих талын чадавх, багшийн ачаалал, нэмэлт ажлууд, цахим хичээл орох орчин нөхцөл, жишээлбэл, сүлжээ барих боломжгүй байдал, сурагчдын хичээлийн оролцоо идэвх зэргийг дурджээ.
- Ерөнхий боловсролын сургуулиуд Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа төлөвлөгөөг загварын дагуу боловсруулаагүй, бүтцийн зарим хэсгийг боловсруулаад зарим хэсгийг боловсруулаагүй, бүтцийн бүрэлдэхүүнд байх хэсгийг тусад нь бүлэг болгон оруулсан, төлөвлөгөө болон төлөвлөгөөний бүтцийн зарим бүрэлдэхүүн хэсгийн нэршлийг өөрөөр нэрлэсэн байна.
- Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг нэг ч сургууль боловсруулаагүй байна.
- “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-нд гамшгийн үед авах арга хэмжээг, “Аюулт үзэгдэл, гамшиг ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд гамшгийн өмнө авах арга хэмжээг тусгасан байдал ажиглагдаж байна.
- Хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага, хугацааг бүх төлөвлөгөөнд тусгасан боловч гал түймрээс сэргийлж ямар ажил зохион байгуулах, галын буланг яаж шинэчлэх, шаардлагатай ямар багаж хэрэгслийг хэдэн ширхэгийг авах зэргээр шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаагүй байна.
- Хэрэгжүүлэх арга хэмжээний хугацааг “1 дүгээр улирал”, “хуурайшилтын үед”, “тухайн үед”, “тухай бүр” зэргээр тодорхой бус тусгасан байна.
- Ерөнхий боловсролын сургуулиуд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг цаг агаар зудын эрсдэлт нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөний загварын дагуу төлөвлөгөөний үндсэн болон хавсралт хэсгийг бүрэн тусгасан, үндсэн хэсэгт хамаарах төлөвлөгөө тус бүрийг бүтцийн бүхий л бүрэлдэхүүн хэсгийг хамруулан тодорхой, хэмжигдэхүйц байхаар боловсруулах талаас нь дэмжлэг хэрэгтэй байна. Төлөвлөгөөнд тодотгол хийхдээ ус цаг уур, орчны шинжилгээний албанаас зарлан мэдээлж буй цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан тодотгол хийсэн шалтгаан утгыг тодорхой он сар өдөртэй бичих талаар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.
- Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиуд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлагдсан төлөвлөгөөний загварын дагуу бус гамшгийн өмнө, үед, дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хугацаа, хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага гэсэн бүтэцтэйгээр боловсруулсан байна. Хүн амын мэдээллийн сан үүсгэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн талаар дурдаагүй байна.

- Сургуулийн дотуур байрны барилгын 56 хувь нь хуучин ашиглалтын хугацаа дууссан үүн дотроо 24.3 хувь нь акталсан барилга байгаа нь маш өндөр эрсдэлийг бий болгож байна.
- Сургууль болон дотуур байранд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой ба 26.8 хувь нь 7-10 тээврийн хэрэгсэл машин багтах зайтай байна.
- Аймгийн төвийн дотуур байр нь аюул тохиолдсон үед хамгаалах хэрэгсэл хангалтгүй байна.
- Галын аюул тохиолдсон үед өргөн хэрэглэгддэг МРЯ-4 гал унтраах хэрэгсэлийн 30.0 гаруй хувь нь ажиллахгүй хугацаа нь дууссан байна. Аймгийн төвийн дотуур байрны хувьд ажиллахгүй үзмэр хэлбэрээр байршуулсан байгаа нь шаардлага хангахгүй байна.
- Сургууль болон дотуур байр нь галын аюулын үед ашиглах элс болон эсгийтэй байх шаардлагатай байдаг ба судалгаанд хамрагдсан сургууль дотуур байрны хувьд элстэй буюу элсний хайрцаг байрлуулсан байна.
- Сумын сургуулийн дотуур байр нь онцгой байдлын үед тухайлбал объектын гал түймэр, газар хөдлөлтийн үед хэрэглэх багажгүй байгаа нь түүгээр хангах шаардлагатайг илэрхийлж байна.
- Сургууль, дотуур байр нь гагнуурын аппарат, сантехникийн багц багаж, цахилгааны багажтай байх шаардлагатай бөгөөд аймгийн төвийн сургууль багц багажтай, сумын сургуулийн 50 хүрэхгүй хувь нь багажтай байгаа учир багажаар хангах шаардлагатай байна.
- Аймгийн төв, сумын сургууль болон дотуур байрны 60.0 гаруй хувь нь эрүүл мэндийн багц цүнхтэй байна.
- Судалгаанд хамрагдсан сургууль, дотуур байрны хувьд хаалга түлхэж онгойдог урсгалтай аймгийн төвийн сургуулийн гарц чөлөөтэй, гарцын тэмдэглэгээ харанхуйд гэрэлтдэг байна. Сумын сургууль болон сумын дотуур байрны хувьд гарцыг чөлөөтэй нэвтрүүлдэг болгох шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Онцгой нөхцөл байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, суралцагчдын хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдахаас сэргийлэхэд дараах зөвлөмжийг хүргэж байна.

Сургуулийн бэлэн байдлыг хангах

Хичээл сургалтын агуулга, төлөвлөгөө бэлтгэх

- Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг богино хугацаанд хэрэгжүүлж болохуйц хэлбэрээр оновчтой боловсруулах
- Онцгой нөхцөл байдал зудын үед хичээлдээ ирэх боломжгүй сурагчдад цахим болон теле хичээлийн арга зүйг боловсруулж, сургалтын цахим санг бүрдүүлж, шаардагатай тохиолдолд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэвшүүлэх

Багш эцэг эхчүүдийг чадавхжуулах

- Онцгой нөхцөлд хичээл сургалтын үйл ажиллагааг явуулах арга зүйн талаар мэргэжлийн байгууллагууд зөвлөн туслан үйл ажиллагааг сургууль, багш нарт явуулдаг байх
- Эцэг эхчүүдэд хүүхдээ гэр бүлийн орчинд сургалт хөгжлийн үйл ажиллагааг нь хэрхэн дэмжих, оновчтой хяналт тавих, сургууль багш нартай хэрхэн хамтрах талаар зөвлөн туслах үйл ажиллагааг явуулах

Холбоо харилцааг бэхжүүлэх

- Багш, сурагч, эцэг эхчүүдийн хооронд мэдээлэл солилцох байнгын сувгийг тодорхойлох (*мессенжер групп, цахим шуудан гэх мэт*)
- Багш, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хуваарьтай уулзалт зохион байгуулж дадах

Техник, технологийн хязгаарлагдмал байдалтай холбоотой шийдэл гаргах

Интернэт холболт муу эсвэл байхгүй тохиолдолд

- Теле хичээл: Теле хичээлүүдийг сургалтын хөтөлбөр, сэдэв, багш өөрийн үйл ажилагаатай хослуулан ашиглах
- Радио хичээл: Радио долгионоор дамжуулан үндсэн хичээлийг заах контент бэлтгэх. Энэ нь интернэтгүй газарт үр дүнтэй.
- Хэвлэмэл материал: Хичээлийн агуулгыг цомхон байдлаар хэвлэж, багцаар сурагчдад хүргэх. Эдгээрийг багш нар өөрийн гарын авлага хэлбэрээр бэлтгэж болно.

Техник хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх

- Түр хэрэгслээр хангах: Орон нутгийн засаг захиргаа болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр зөөврийн компьютер, таблет, гар утас зэргийг сурагчдад түр ашиглуулахаар зохицуулах.

- Хамтарсан төхөөрөмжийн ашиглалт: Нэг гэр бүлийн сурагчид хамтдаа нэг төхөөрөмж ашиглах боломжийг дэмжих.

Хичээл сургалтын үйл ажиллгааг оновтой зохион байгуулах

Теле болон цахим сургалтын уялдаа:

- Теле хичээлээр заасан агуулгыг бататгах зорилгоор сурагчдад дасгал, даалгавар өгөх. Эдгээрийг интернэттэй сурагчдад онлайнаар, харин интернэтгүй сурагчдад хэвлэмэл материал хэлбэрээр хүргэх, хичээлийн үр дүнг үнэлэх, үнэлгээн дээр тулгуурлан сайжруулалтыг хийж дадах
- Цахим платформ ашиглах: Интернэттэй сурагчид Zoom, Google Classroom зэрэг платформыг ашиглаж, харин интернэтгүй сурагчдад холбогдох дасгал ажлыг хэвлэмэл материал хүргүүлж хичээлийн үр дүнг үнэлж, үнэлгээн дээр тулгуурлан сайжруулдаг байх

Багш нарын уян хатан арга зүй

- Анги удирдсан багш нар өөрийн ангийн сурагчдын нөхцөл байдалд тохируулан хичээлийн төлөвлөгөөг өөрчлөх.
- Сурагчдын нас, хэрэгцээнд нийцсэн сонирхолтой, хялбаршуулсан аргаар хичээл заах арга зүйд суралцах.

Гэрийн даалгавар болон шалгалт

- Гэрийн даалгаврыг сурагчдын нөхцөл байдалд нийцүүлэн хөнгөвчилсөн, хэрэгжүүлэхэд амар байдлаар өгөх.
- Шалгалт болон үнэлгээг нөхцөл байдлаас хамааран цахимаар эсвэл цаасан хэлбэрээр зохион байгуулах.

Багш нар болон эцэг эхчүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх

Багш нарыг дэмжих:

- Теле болон цахим сургалтуудыг багш нарт зориулан мэргэжлийн сургалтын байгууллагууд нь зөвлөн туслах, зохион байгуулах. Жишээ нь: Zoom ашиглаж судлагдахуун бүрээр аргачлал, теле хичээлийн үр дүнг нэмэгдүүлэх зөвлөгөө өгөх.
- Багш нарт хичээл бэлтгэхэд шаардлагатай материал, зааварчилгаа өгөх.

Эцэг эхчүүдийн оролцоо:

- Эцэг эхчүүдэд хүүхдүүдийн гэрийн даалгавар, суралцах орчныг хэрхэн зохион байгуулах талаар заавар зөвлөгөө өгөх.
- Эцэг эхчүүдийг сургалтын процессын нэг хэсэг болгох, тухайлбал: өдөр тутмын даалгаврыг шалгах, урам зориг өгөх.

Сэтгэл зүйн дэмжлэг

Сэтгэл санааны дарамтыг бууруулах

- Багш нар сурагчидтай байнгын холбоотой байж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх.
- Сурагчдад бие даан суралцахын ач холбогдлыг ойлгуулах, урамшуулах үйл ажиллагаа зохион байгуулах, сургуульдаа ирсний дараа хичээлийн хоцрогдол байгаа гэж үзвэл, хоцрогдлыг арилгахын тулд хичээл нөхөх, давтлага өгөх гэх мэт үйл ажиллагааг сургуулийн түвшинд албан ёсоор зохион байгуулдаг байх, үр дүнг нь албан ёсоор үнэлдэг байх

Гэр бүлд чиглэсэн дэмжлэг

- Эцэг эх асран хамгаалагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах
- Эцэг эх асран хамгаалагчдад зориулсан онлайн уулзалт эсвэл зөвлөгөө зохион байгуулж, тэдний сэтгэл санааг хуваалцах, зөвлөн туслах ажлыг хийдэг байх

Санхүүгийн болон техникийн дэмжлэг

Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас дэмжлэг авах

- Сургалтын хэрэгслийг сурагчдад хүргэхэд шаардлагатай төсөв гаргах, хандив цуглуулах санаачилга гаргах.
- Орон нутгийн радио, телевизтэй хамтран теле хичээл дамжуулах.

Хувийн хэвшлийн оролцоо

- Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудаас техник хэрэгсэл, интернэтэд холбогдох үйлчилгээний дэмжлэг авах.
- Дотоодын компаниудтай хамтарч, сургалтын материал хэвлэх, тараах зардлыг бууруулах.

Үр дүнгийн хяналт, тайлагнал

Хичээл сургалтын чанарт хяналт тавих

- Багш нар сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг тогтмол хянаж, уялдаа холбоотой байх.
- Багш нар болон эцэг эхчүүдээс санал хүсэлт авч, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах.

Үнэлгээний систем

- Сургалтын үр дүнг тооцох тусгай шалгуур боловсруулж, теле болон цахим сургалтын үр нөлөөг дүгнэх менежментийг хэрэгжүүлдэг байх нь чухал байна.

НОМ ЗҮЙ

1. Lawrie, J. and Dandii, O. 2010. Report on the 2009-10 Dzud Disaster Impact on Schools, Kindergartens, Childrens and Teachers in Mongolia. Ulaanbaatar, Save the Children Japan.
2. Монгол Улсын стандарт, 2021. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага, Улаанбаатар хот.
3. БШУ-ны сайдын 2021 оны А/190 дүгээр тушаал. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө, 2021-2023.
4. Зудын эрсдэлийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэх нь: Малын хорогдлын загвар ба зудын эмзэг байдлын олон үзүүлэлтэт индекс.
5. Японы хүүхдийг ивээх сан, 2017. Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага. Улаанбаатар хот.
6. БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2019. Боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл.
7. НҮБХХ, Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) 2010. Зудын үндэсний тайлан 2009-2010. Улаанбаатар хот, НҮБХХ, ОБЕГ.
8. Лори, Ж., Д.Одгэрэл, О. 2010. Монгол Улсын сургууль, цэцэрлэг, хүүхэд, багш нарт 2009-2010 оны зудын гамшиг нөлөөлсөн байдлын тайлан. Улаанбаатар, Японы Хүүхдийг ивээх сан.
9. Үндэсний статистикийн хороо, 2022. Тайлан. Улаанбаатар хот.
10. Барилга хөгжлийн төв, 2020. “Нийгмийн дэд бүтцийн хангамж, хэрэгцээ, хэтийн төлөвийг боловсрол тодорхойлох” гэрээт ажлын тайлан. Улаанбаатар хот.
11. Гамшиг судлалын үндэсний төв, 2021. Судалгааны ажлын эмхэтгэл. Улаанбаатар хот.
12. Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент 2016. Сургуулийн удирдлага, багш ажилчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар хот.
13. Engel, J. and A. Prizzon (2014). *From decline to recovery: Post-primary education in Mongolia*. London: Overseas Development Institute.
14. Dairii, A. and T. Suruga (2006). Economic Returns to Schooling in Transition: A Case of Mongolia. *GSICS Working Paper Series* 9.
15. БШУЯ., Save the children., World Vision., 2018. Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа., Улаанбаатар хот.
16. <https://montsame.mn/mn/read/274009>
17. www.legalinfo.mn
18. <https://odi.cdn.ngo/media/documents/9053.pdf>
19. <http://w.tsag-agaar.gov.mn/>